

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

- 1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР**
- 2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД**
- 3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 4. ЭД ХӨРӨНГӨ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 5. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 6. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 7. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 8. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 9. ДҮГНЭЛТ**

1. БОДЛОГО ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/424 тоот тушаалаар батлагдсан бүтэц орон тооны дагуу Төрийн захиргааны 36 үндсэн ажилтан, төрийн үйлчилгээний 5 үндсэн ажилтан, гэрээт 4 албан хаагч нийт 45 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, иргэний улсын бүртгэгч 30, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 1, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч 3, ерөнхий нягтлан бодогч 1, мэдээлэл технологийн ажилтан 1, бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, архивч 2, гэрээт ажилтан 4 тус тус ажиллаж байна.

2024 оны тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан. Мөн Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, улсын бүртгэгч нарт холбогдох чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

2024 тайлант хугацаанд УБЕГ-ын даргын 15 тушаал, 35 чиглэл, 13 албан даалгавар, Даргын зөвлөлийн хурлаас өгсөн 9, удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн 20 үүрэг даалгаврыг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 41 удаагийн цахим болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.

Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хууль болон Аймаг, Нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, сонгуулийг зохион байгуулах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь ханган, 2 шатны сонгуулийг амжилттай зохион байгуулсан. 2024 оны сонгуулийн хувьд сонгогчийн ирц бүртгэлийн програм онлайн сүлжээнд ажилласнаараа илүү онцлог, хариуцлага өндөр байсан бөгөөд Хөвсгөл аймгийн 129 хэсгийн хорооны сүлжээний хэвийн байдлыг урьдчилан шалгаж, туршилтын сонгуулийг амжилттай зохион байгуулсаны үндсэн дээр сонгуулийн өдөр алдаа зөрчилгүй ажиллалаа. Монгол Улсын Их хурлын сонгуулийн сургалтыг Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын Б.Гантөмөр даргаар ахлуулсан баг, АНСДИТХ-н сонгуулийн сургалтыг Хэлтсийн дарга Б.Мөнгөнзул болон МТГ-н инженер Э.Мөнхжин нар амжилттай удирдан зохион байгуулсан.

Монгол Улсын Их хурлын болон Аймаг ,нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиар 246.962.768 төгрөгний санхүүжилтыг зориулалтын дагуу зарцуулсан.

Хэлтсийн 35 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, тайлант хугацаанд шинээр томилогдсон 4 нийт 39 албан хаагчийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан Баталгааны маягтыг УБЕГ-т хүргүүлэн, нууцын баталгааг гаргуулан ажилласан. Мөн Авилгатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контент, мэдээллийг товш, авлигад дасах ёсгүй, буруу аргаар олж авсан баялаг бүтэн амьдралыг ч сүйрүүлнэ, муу найз үлгэрийн баатруудыг хэрхэн зурах бэ, зоосон нүдлэсэн бүхнийг, танил тал, албан тушаалаараа далайлгасан үйлдэл болгосныг бүү тэвч, шударга ёс хөгжил дэвшилд 110 авлигыг мэдээлэх утас, шидэт харандаа зэрэг подкаст мэдээллийг байгууллагын цахим хуудас болон фейж хуудсанд цаг тухай бүрт түгээн ажиллаж байна.

Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 40 арга хэмжээтэйгээр боловсруулан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан, 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 40 арга хэмжээнээс тайлант хугацаанд 40 арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 51488 иргэнд буюу 57%-тай байсан бол 2024 оны тайлант хугацаанд **20973** иргэнд тоон гарын үсэг олгож, нийт **72461** иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсэг олгох ажил **80.09%**-тай явагдаж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа улсын бүртгэлийн 3 киоск машины 2 нь Мөрөн суманд хэлтсийн байранд болон, төв Хаан банкны байранд, 1 нь Рэнчинлхүмбэ суманд байршиж байгаа бөгөөд тайлант хугацаанд хийт 9936 иргэн улсын бүртгэлийн киоск машинаас 12 төрлийн лавлагаа авсан байна.

Тус хэлтсийн 1-10 дугаар сарын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаар 1 удаагийн инфографик мэдээллийг үнэн зөв гарган тус, хэлтсийн цахим хуудас болон хэлтсийн ил тод байдлын самбар, олон нийтийн сүлжээнд байршуулан, хэлтсийн цахим хуудас, фейсбүүк фейж хуудсанд 10 мэдээллийг оруулан, 274 удаагийн давтамжтай түгээн ажиллаж байна.

Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд иргэдээс 128 өргөдөл, гомдол хүлээн авж 100% шийдвэрлэсэн бөгөөд 1,2,3 дугаар улирлын өргөдөл гомдлын мэдээг УБЕГ-т хугацаа хоцроолгүй үнэн зөв хүргүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Хатгал, Улаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон Ингэснээр 12 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл **823**, хуулийн этгээдийн улсын бүртгэл **110** хөтлөгдсөн байна. Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх болсонтой холбоотойгоор иргэдийн эд хөрөнгөө бүртгүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах таатай нөхцөл бүрдсэн ч нотариатын үүрэг гүйцэтгэгч, газрын даамал, иргэдийн хурал /газрын хаягжилтын тогтоол/, банк зэрэг байгууллагын албан хаагчдыг ажлын хариуцлагын сайжруулах, чадавхжуулах тал дээрх байгууллагын дээд шатны удирдлагатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Тус хэлтэс нь Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс Мөрөн, Тариалан, Рэнчинлхүмбэ, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган сумдад нэвтрүүлэхээр нийт 42.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн Улсын бүртгэлийн хэлтэст үндэсний энгийн гадаад паспортыг бүртгэл хөтлөх дадлага хийж гадаад паспортын бүртгэлийг тухайн сумандаа хөтлөн ажиллаж байна. Ингэснээр нийт 9 суманд гадаад паспортын бүртгэл хөтлөх боломж бүрдсэн.

Иргэний улсын бүртгэлийг өмнөх оны тайлант хугацаатай харьцуулахад 1.38%, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 0.6%, хуулийн этгээдийн улсын бүртгэл 31%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэл өссөн нь Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд хоршооны бүртгэлийг 2023 оны тайлант хугацаатай харьцуулахад 205 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД

Нэг. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал:

Хөвсгөл аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч, зуд болсонтой холбогдуулан “Хоймор нутгийн малчин танд туслья” аянд хэлтсийн албан хаагчдын зүгээс 505,000 төгрөгийн хандив цуглуулан Хөвсгөл аймгийн онцгой комисст, хүлээлгэн өгсөн. Мөн Малчин таны төлөө хоршооны “Малчин таны төлөө сэтгэлийн дэм” хандивын аянд 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр 200.000 төгрөгийг тус тус хандивласан.

Хөвсгөл аймгийн хамгийн алслагдсан сумд болох Рэнчинлхүмбэ, Ханх, Цагааннуур сумдын иргэдэд Улсын бүртгэлийн дараах үйлчилгээг үзүүлсэн.

- 237 иргэний Үндэсний энгийн цахим гадаад паспортын захиалга
- 4 иргэний газар өмчлөх эрхийн гэрчилгээ олгож, 12 иргэнд зөвлөгөө мэдээлэл
- 7 иргэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл тус тус өгч, сумдын Засаг даргын тамгын газар болон холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулж ажиллалаа.

2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Хөвсгөл аймгийн Хөдөө аж ахуйн газартай хамтран “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлтэй зээлийн мэдээлэл өгөх” зорилгоор Нэг цонхны үйлчилгээний төвд хуулийн этгээдийн улсын бүртгэгч П.Даваадулам ажиллаж 31 иргэнд зөвлөгөө мэдээлэл, 5 хуулийн этгээдэд хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагааг өгч ажиллалаа.

2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр “Хуульчийн Про-Боно” өдөрлөгт оролцож иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, тоон гарын үсэг олгосон.

2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр тус тасгийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч П. Даваадулам Бүрэнтогтох суманд ажиллаж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумын иргэдэд газар дээр нь үзүүлсэн бөгөөд 19 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч 2 хуулийн этгээдэд хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа олгосон байна.

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд Алаг-Эрдэнэ суманд хэлтсийн даргаар ахлуулсан баг ажиллаж, сумын иргэдэд хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх тухай мэдээллийг хэлтсийн дарга Б.Мөнгөнзул өгч, хоршооны бүртгэлийг улсын бүртгэгч Б. Цэнд-Аюуш газар дээр нь бүртгэж ажилласан.

2024 оны 05 дугаар сарын 17, 18-ний өдрүүдэд Хөвсгөл аймгийн Мөрөн суманд зохион байгуулагдсан “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” зөвлөгөөнд оролцож буй 23 сум, 1 тосгоны 1000 малчинд хэлтсийн дарга Б.Мөнгөнзул хоршоог улсын бүртгэлд хэрхэн бүртгүүлэх, хоршооны мэдээлэлд хэрхэн өөрчлөлт оруулах талаар мэдээлэл өгч, улсын бүртгэгч Б.Цэнд-Аюуш, П.Даваадулам нар хоршооны бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж, хоршооны нэр баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.

5 дугаар сарын 20-ны өдөр “Шинэ хоршоо хөдөлгөөн”-тэй холбогдуулан Мөрөн сумын малчдын зөвлөгөөнд хуулийн этгээдийн улсын бүртгэгч П. Даваадулам оролцож, “Хоршоог улсын бүртгэлд хэрхэн бүртгүүлэх”, “Хоршооны мэдээлэлд өөрчлөлт оруулах” зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч малчдын сонирхсон асуултанд хариуллаа.

Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний хөгжлийн төвтэй хамтран 4G зөөврийн тоног төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “Хамтдаа нөлөөлье” аянд оролцож 15 иргэнд тоон гарын үсэг олгон ажилласан.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран “Ирээдүй XXI зуун” Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 28 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор мэргэжил сонголтонд арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын үйл ажиллагаатай танилцах судалгаат аяллыг зохион байгуулсан.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Нийтийн эдэлбэр газар, орчны бүх нийтийн хог хаягдал цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай" А/101 захирамжийн дагуу Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь орчны 50 метр хүртэлх газар болон нийтийн хог хаягдлыг цэвэрлэлээ.

Тус хэлтэс нь “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 516 ширхэг мод тарьснаас 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Гандандаржайлин хийд болон “Амгалан Дэлхий” төсөлтэй хамтран 50 ширхэг гүйлс, 05 дугаар сарын 18-ны өдөр “Ээлтэй мөрөн” хөтөлбөрийн хүрээнд Мөрөн сумын 5 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбайд 50 ширхэг хайлаас, 10 дугаар сарын 05-ны өдөр “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд Мөрөн сумын 1 дүгээр багийн Төгөл сааданд мод 50 ширхэг улиас, саваа модыг тус тус тарьсан байна.

Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын түүхт 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Цагдаагийн газар болон дотоодын цэргийн 9 албан хаагчдын гэр бүлийн бүртгэлийг хөтөлж, гэрлэлтийн гэрчилгээ олгох ажлыг ёслол төгөлдөр зохион байгууллаа.

2024 оны 08 дугаар сарын 26, 27-ны өдөр Худалдаа аж үйлдвэрлэлийн танхимтай хамтран хуулийн этгээдийн улсын бүртгэгч П.Даваадулам нь “Худалдаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал ба шийдэл” хэлэлцүүлэг арга хэмжээнд оролцож компани байгуулах болон өөрчлөлтийн бүртгэлийн талаар иргэдэд зөвлөгөө мэдээллэл өгч ажиллалаа.

2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Статистикийн 100 жилийн ойд зориулсан “Статистикийн шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид мэдээллэгч байгууллагуудад танилцуулах арга хэмжээ” нээлттэй хаалганы өдөрлөгт, иргэний улсын бүртгэгч Б.Мөнхжаргал, Хуулийн этгээдийн бүртгэгч П.Даваадулам нар иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг танилцуулж мэдээллэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Мөн Эрдэнэбулган, Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд Үндэсний гадаад паспортын бүртгэлийн тоног төхөөрөмж шийдвэрлэж 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 07 дугаар сарын 26-ны өдрийн хооронд Эрдэнэбулган сумын Улсын бүртгэгч Э.Сосорбурам, 2024 оны 10 дугаар сарын 28-аас 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан нар Улсын бүртгэлийн хэлтэст үндэсний энгийн гадаад паспортыг бүртгэл хөтлөх дадлага хийж гадаад паспортын бүртгэлийг тухайн сумандаа хөтлөн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/1005 тоот “Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай” албаг бичгийн дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.

“Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Хөвсгөл аймгийн Авьяас Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 38 сурагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор мэргэжил сонголтонд арга зүйн зөвлөгөө өгөх, байгууллагын үйл ажиллагаатай танилцах судалгаат аяллыг зохион байгуулсан. Мөн Цагаан-Үүр сумын улсын бүртгэгч Б.Долгорсүрэн 6-10 дугаар ангийн 203 сурагчид ажил мэргэжлээ сурталчласан.

Хөвсгөл аймгийн 137000 гаруй иргэнд зөөврийн тоног төхөөрөмжөөр гадаад паспортын үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад хүсэлтийг уламжлан, 10 000 000 төгрөгийн төсвийг шийдвэрлүүлэн гадаад паспортын бүртгэлийн иж бүрэн тоног төхөөрөмжтэй болж, иргэний улсын бүртгэгч Б.Болормаад хүлээлгэн өгсөн.

Монгол улсын Их хурлын болон Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хүрээнд сүлжээ шалгах ажлаар Аймаг, сумын сонгуулийн хороо болон мэдээлэл технологийн даамалтай, Улсын бүртгэлийн байгууллагын 129 хэсгийн хороонд ажиллах 131 итгэмжлэгдсэн ажилтны судалгаа болон сургалтын үйл ажиллагааг Тагнуулын хэлтэстэй хамтран, сонгуулийн ирц бүртгэлийн програм бүхий тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангахад Цагдаагийн газартай тус тус хамтран ажиллалаа.

Хоёр. Нэгжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд

Хэлтсийн байрны 1 давхар болох үйлчилгээний заал болон, Хаан банк, Рэнчинлхүмбэ сумын сумын засаг даргын тамгын газарт “Цахим үйлчилгээний 24/7” буланг ажиллуулан тайлант хугацаанд 9936 лавлагаа, 3990 тоон гарын үсэг олгон ажилласан.

2024 оны тайлант хугацаанд хэлтсийн 15 хурал, даргын зөвлөлийн 28 хурал, сумын улсын бүртгэгч нарын 21 цахим хурал тус тус болсон бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтлөн албажуулж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаас өгсөн 15, удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн 20 удаагийн үүрэг даалгаврыг хэлтсийн албан хаагчдад тухай бүрт танилцуулан, биелэлтийг хуулийн хугацаанд нь УБЕГ-т хүргүүлэн ажилласан.

Тус хэлтсийн <https://khuvsgul.burtgel.gov.mn/> цахим хуудсанд байршуулбал зохих нээлттэй мэдээллийг байршуулах хугацаа, давтамжийн дагуу байршуулж хэвшсэн бөгөөд, дутуу мэдээллийн нөхөн байршуулж, нийт 424 мэдээлэл байршуулсан. Тус хэлтсийн 2023 оны II, III, IV дүгээр улирлын болон 2024 оны I дүгээр улирлын өргөдөл, гомдлын мэдээг нөхөн байршуулсан. Хэлтсийн цахим хуудсанд байршуулах улирал, хагас жил, сар бүр, тухай бүр байршуулах тайлан, сар бүрийн тоон мэдээ, цаг үеийн мэдээ мэдээллийг өдөр бүр байршуулан ажиллаж байна. Цахим хуудасны “Танилцуулга” цэсэнд байгаа нэгжийн бүтэц, албан тушаалтан, утасны мэдээллийг шинэчлэн, иргэдэд илүү ойлгомжтой байдлаар бүтцийн мэдээллийг шинэчлэсэн.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 49 дүгээр “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” тогтоолын дагуу авлигатай тэмцэх 5 үйл ажиллагааны 1 болох Шил ажиллагаа нь ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Уг ажлын хүрээнд shilen.gov.mn сайтад 5 чиглэлийн 87 мэдээллийг байршуулан ажиллаж 88.2% үнэлгээтэй байна. 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар IV дүгээр улирлын ил тод байдлын мэдээг оруулна.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, иргэн бүрт хүрч үйлчлэх зорилгоор үйлчилгээний зааланд байрлах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн “Хөтөч” хавтсыг тус бүр шинэчлэн, иргэдэд илүү хялбар байдлаар хэвлэн байршууллаа.

Хууль зүй дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж буй төсвийн гүйцэтгэлийн OPENGOV программд сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон 2025 оны төсвийн төслийг шивж оруулж хэвшсэн.

Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн хэмжээнд Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Бүрэнтогтох, Ханх сумдын улсын бүртгэгч нарын ажлын байрны сул орон тоо Улсын бүртгэлийн ерөнхий газрын Төрийн албаны салбар зөвлөлийн захиалгаар зарлагдаж тусгай шалгалтад тэнцсэн иргэд Улсын бүртгэгчийн албан тушаалд томилогдсон.

Гурав. Идэвхи санаачлага, шинэлэг ажлын хүрээнд:

Хэлтсийн хамт олноос гаргасан шинэ, шинэлэг санаачлагаар “Бүртгэлхүү, Бүртгэлмаа” нэртэй контентыг эхлүүлсэн бөгөөд тайлант хугацаанд “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл”, “Цахим гадаад паспорт”, “Тусгай хэрэгцээт иргэнд гэрт нь очиж бүртгэл хөтлөх” “Тоон гарын үсэг” “24/7 үйлчилгээ” “Ногоон нэгж” гэсэн 6 сэдвээр бүтээж цахим хуудсанд байршуулаад байна. Энэхүү контент нь бүртгэл тус бүрээр цаашид үргэлжлэх бөгөөд шинэ контентыг тухай бүр цахим хуудаснаа байршуулан бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг анхан шатны нэгжээс үзүүлэх ажлын хүрээнд аймгийн төвөөс хол, алслагдсан Тариалан, Цагаан-Уул, Цэцэрлэг, Их-Уул сумдад нэвтрүүлэхээр нийт 12.140.000 төгрөгийн төсвийг сумын ИТХ-р шийдвэрлүүлэн гадаад паспортын бүртгэл хөтлөх тоног төхөөрөмж /зургийн аппарат, гэрэлтүүлэгч иж бүрэн, хөшиг/ болон үйлчилгээний хураамж төлөх гэрэгэ пос төхөөрөмжийг худалдан авч, сумдын улсын бүртгэгч нарыг хэлтэст дадлага хийлгэн, үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийг хөтлөх эрхийг нээлгэх албан бичгийг УБЕГ-т хүргүүлэн эрх авч, 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр “ГЭРТ ОЙР, ГАРТ ОЙР ГАДААД ПАСПОРТ” уриатай гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг сумаасаа авах үйл ажиллагааг албан ёсоор нээж бүртгэлийн үйлчилгээг иргэн бүрт улам ойр болгон ажиллаж байна. Мөн Эрдэнэбулган, Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд Үндэсний гадаад паспортын бүртгэлийн тоног төхөөрөмж шийдвэрлэж Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан, Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч Э.Сосорбурам нар Улсын бүртгэлийн хэлтэст үндэсний энгийн гадаад паспортыг бүртгэл хөтлөх дадлага хийж гадаад паспортын бүртгэлийг тухайн сумандаа хөтлөн ажиллаж байна.

Мөн Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумын улсын бүртгэгч нар гадаад паспорт бүртгэлийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг зохион байгуулж, бүртгэл хөтөлж эхлэхэд бэлэн болсон байна.

Эрдэнэбулган сумын ИТХурал, ЗДТГазрын хүсэлтээр тус суманд 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр ажиллаж 90 иргэнд гадаад паспортын үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. Мөн ОХУ-н Тува улсын тож хошуун дахь төрөл төрөгсөд, ахан дүүстэйгээ 60-70 жил уулзаагүй цаатан иргэдийг ахан дүүстэйгээ уулзах боломжийг бүрдүүлэх зорилгоор аймгийн төв орж гадаад паспорт захиалах боломжгүй цаатан иргэдэд 2024 оны 4-р сарын 13 наас 15 ны өдрүүдэд хүрч үйлчлэн “ЦААТНЫ УРЦАНД-ЦАХИМ ГАДААД ПАСПОРТ” өдөрлөгийг зохион байгуулан 106 иргэд гадаад паспортын үйлчилгээг үзүүлсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор суманд амьдардаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд өвчтэй болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөөврийн 4G төхөөрөмж ашиглан тоон гарын үсэг олгох, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний улсын бүртгэлийн лавлагаа зэрэг 27 иргэнд үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.

- 01 сарын 23-ны өдөр Тариалан сумын улсын бүртгэгч М.Номиндарь
- 04 сарын 23-ны өдөр Баянзүрх сумын Улсын бүртгэгч Н.Азжаргал
- 05 сарын 24-ны өдөр Мөрөн сумын улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн
- 11 дүгээр сарын 06-07-ны өдөр Галт сумын улсын бүртгэгч Д.Элбэгзаяа
- 11 дүгээр сарын 09-ны өдөр Арбулаг сумын улсын бүртгэгч А.Батцэнгэл
- 11 дүгээр сарын 11-ний өдөр Тариалан сумын улсын бүртгэгч М.Номиндарь
- 11 дүгээр сарын 15-16-ны өдөр Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч Э.Сосорбурам

Хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах иргэдэд үйлчилгээ үзүүлдэг текийг намсгаж, шинээр сандал худалдан авч тусгай хэрэгцээт болон өндөр настан иргэдэд үйлчилгээний стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. Тухайн ажлыг хэлтсийн албан хаагчид амралтын өдрөөрөө өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэлээ. Мөн хэлтсийн гадна машины зогсоолд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан тусгай тэмдэг тэмдэглэгээг хийж байршууллаа.

Улаан-Уул сумын Улсын бүртгэгч Т.Энхбаяр сумын ЗДТГ-тай сумын төсвөөс 620,000 төгрөг шийдүүлэн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлдэг өрөөг тохижуулсан.

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 84 жилийн ой “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг угтан хэлтсийн 101 тоот өрөөний тохижилтыг сайжруулан ханын зураг зуруулан мөн шинэ төрсөн хүүхэд бүртгүүлэхээр хүүхэдтэйгээ ирсэн эцэг, эхчүүд хүүхдээ унтуулах, хуурайлах тав тухтай орчинг бүрдүүлэн ажиллалаа.

Архивын үйл ажиллагааны хадгалалт, хамгаалалтыг хангах үүднээс хэлтсийн 1 давхрын 8 цонхонд төмөр хамгаалалт хийж гүйцэтгэсэн.

Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний нэг болох хэлтсийн үйлчилгээний зааланд дугаар дуудах машин ашиглаж эхэлсэн бөгөөд, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг 8 цонхонд дугаар дуудагч машиныг өдөр тутамдаа ажиллуулж хэвшсэн. Дугаар дуудагч машины төсвийг 4.000.000.00 сая төгрөгийг хэлтсийн урсгал санхүүжилтийн шийдвэрлэсэн.

Дөрөв. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд

Цахим гарын үсгийн тухай хууль, улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын 30 албан хаагч, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв”-ийн 15 албан хаагч, Мөрөн сумын ЗДТГ-ын 54 албан хаагч, болон “ИРГЭДЭЭ СОНСЪЁ” өдөрлөгт 40 иргэнд, Хуульчдийн “Про боно” өдөрлөгт 10 иргэнд, сумдын “ХААН БАНК”-наас үйлчилгээ авч байгаа 254 иргэнд цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 51488 иргэнд буюу 57%-тай байсан бол 2024 оны тайлант хугацаанд **20973** иргэнд тоон гарын үсэг олгож, нийт **72461** иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсэг олгох ажил **80.09%**-тай явагдаж байна.

Тав. Нээлттэй хаалганы өдөр

Хөвсгөл аймгийн хамгийн алслагдсан сумд болох Рэнчинлхүмбэ, Ханх, Цагааннуур сумдын иргэдэд Улсын бүртгэлийн дараах үйлчилгээг үзүүлсэн.

- 237 иргэний Үндэсний энгийн цахим гадаад паспортын захиалга
- 4 иргэний газар өмчлөх эрхийн гэрчилгээ олгож, 12 иргэнд зөвлөгөө мэдээлэл
- 7 иргэнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл тус тус өгч ажилласан.

2024 оны 03 дугаар сарын 14, 15-ны Тариалан, Их-Уул, Эрдэнэбулган сумдад гадаад паспортын үйлчилгээг нэвтрүүлж “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн бөгөөд цахим гадаад паспортын үйлчилгээг үзүүлэн, Эрдэнэбулган суманд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн үйлчилгээг-5 иргэнд үзүүлж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг газар дээр нь олгосон байна. Тариалан суманд барьцааны гэрээ дуусгавар болгох-5 бүртгэл, лавлагаа-4, худалдах худалдан авах гэрээ-2, хаяг өөрчлөх-13 бүртгэлийг тус тус газар дээр нь хүлээн авч бүртгэл хөтөлсөн. Их-Уул суманд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн-1, бэлэглэлийн гэрээ-2, газрын хэмжээ өөрчлөх-2 бүртгэлийг тус тус хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл зөвлөгөөг нийт 32 иргэнд өгч ажилласан байна.

2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Аймгийн засаг дарга П. Лхагважавын санаачлагаар зохион байгуулсан төрийн байгууллагуудын “Иргэдэдээ сонсьё -2024” нээлттэй хаалганы өдөрлөгт иргэний улсын бүртгэгч Б.Мөнхжаргал, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч З.Бямбасүрэн, хуулийн этгээдийн улсын бүртгэгч П. Даваадулам нар оролцож эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 39 иргэнд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 26 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 3 хуулийн этгээдийн нэр баталгаажуулсан байна.

2024 оны 04 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд Цагааннуур суманд зохион байгуулсан “Цаатны урцанд - Цахим гадаад паспорт” нээлттэй өдөрлөгт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч З.Бямбасүрэн оролцож эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 21 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, 1 иргэнд газар өмчлөх эрхийн гэрчилгээ олгон ажилласан.

2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр ХЗДХЯ-ны харъяа агентлаг, байгууллагуудын дунд зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрт иргэний улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн оролцож ИУБ-31 бүртгэл 5, лавлагаа 9, тоон гарын үсэг 17, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б. Цэнд-Аюуш оролцож эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 29 иргэнд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 24 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1 хуулийн этгээдийн нэр баталгаажуулсан байна.

2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Статистикийн 100 жилийн ойд зориулсан “Статистикийн шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид мэдээллэгч байгууллагуудад танилцуулах арга хэмжээ” нээлттэй хаалганы өдөрлөгт, иргэний улсын бүртгэгч Б.Мөнхжаргал, Хуулийн этгээдийн бүртгэгч П.Даваадулам нар иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг танилцуулж мэдээллэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Зургаа. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

2024 оны 05 дугаар сард хэлтсийн болон сумдын нийт 46 албан хаагчдаас ажлын байрны орчин нөхцөлийн талаар сэтгэл ханамжийн судалгааг жишиг загварт нийцүүлэн боловсруулж цахим хэлбэрээр авав.

Эд хөрөнгийн хариуцлагын даатгалд хамруулахаар Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол, Эд хөрөнгө эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ө.Батнасан, Б. Цэнд-Аюуш, З.Бямбасүрэн, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн, Хатгал тосгоны улсын бүртгэгч М.Даваахүү нарын судалгааг Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан байна.

Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн бүх албан хаагчдын хувцаслалтыг 100% жигдрүүлж, бомбер болон поло цамцыг захиалан хийлгэсэн.

Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газар болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд зарим албан хаагчдад газар олгуулах хүсэлтийг хэлтсийн удирдлагын зүгээс хүргүүлсэн.

Нийгмийн баталгааг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2024 оны эхний хагас жилд 02 дугаар сарын 07-ны өдөр , 05 дугаар сарын 01-ний өдөр 2 удаа нийт 13 албан хаагчийг шагналд тодорхойлж Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох материалыг хүргүүлсэн бөгөөд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол нь Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр, Хэлтсийн дарга Б.Мөнгөнзул нь “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан”, Иргэний улсын бүртгэгч Б.Мөнхжаргал нь “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан”, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн нь Хууль зүйн албаны “Тэргүүний ажилтан”, Иргэний улсын бүртгэгч Б.Мөнхзул, Жаргалант сумын улсын бүртгэгч Ө.Түвшинсайхан, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч П.Даваадулам нар нь ХЗДХЯамны “Хүндэт жуух бичиг”, Иргэний баримтын архивч Б.Оюунцэрэн, үйлчлэгч Б.Дуламсүрэн жижүүр Р.Төмөрбаатар нар нь Улсын бүртгэлийн байгууллагын “Жуух бичиг”-ээр шагнуулав. Мөн 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Тариалан сумын улсын бүртгэгч М.Номиндарь, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Цэнд-Аюуш нарыг Улсын бүртгэлийн байгууллагын “Жуух бичиг”-ээр шагнуулахаар тодорхойлолтыг хүргүүлсэн байна.

Хэлтсийн дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр байгууллагын бүх албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйл гардуулсан.

2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр “Маш сайн буюу хангалттай” үнэлэгдэж, 25 албан хаагчийн зэрэг дэв олгуулах хүсэлтийг хүргүүлсэнээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгох тухай” Б/22 тоот тушаал батлагдсаны дагуу зэрэг дэв ахиулан 24, шинээр олгох 1 нийт 25 албан хаагчид зэрэг дэв олгов.

Хэлтсийн хамт олон хүүхдийн нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор 1 бүтэн өнчин хүүхдийг асран хамгаалахад 11 дэх жилдээ дэмжлэг үзүүлэн сар бүр хадгаламжийн дансанд 400 000 төгрөгийн хуримтлал үүсгэн байршуулж нийт 4 400 000 төгрөгийг ирээдүйд нь хувь нэмэр оруулж байна.

Байгууллагын хүүхдийн эрхийг хамгаалах ажлын хүрээнд тохижуулан засварласан хүүхдийн өрөөний хэвийн үйл ажиллагааг хангаж тогтмол цэвэрлэгээ үйлчилгээг хийж, ширээ сандал, тоглоом болон бусад тавилгын бүрэн бүтэн байдал, өрөөний өнгө үзэмжид байнга анхаарч засвар үйлчилгээг хийж албан хаагчдын хүүхдүүд цэцэрлэг, сургуулиа тараад эцэг эхийн ажил дээр ирэх үед хичээлээ хийх, тоглох, хөгжих боломжийг олгож байна.

XVII дугаар жарны “Хилэнт эх” хэмээх модон Луу жилийн Цагаан сарын хүндэтгэлийн золголтыг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хэлтсийн хэмжээнд зохион байгуулж байгууллагын өндөр настны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлснээс гадна Хөвсгөл аймгийн хэлтсийн даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/03 тоот “Ахмадын зөвлөл байгуулах тухай” тушаал батлагдаж “Ахмадын сан” хуримтлалын санг үүсгэхээр нотлох баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.

Орон сууц худалдан авах, ипотекийн зээлд хамрагдахаар төлөвлөж буй албан хаагчдын судалгааг гаргаж, хямд чанар сайтай орон сууцанд орох боломжийг судлах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд эхний хагас жилд ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Цэнд-Аюуш нар нь шинэ баригдсан орон сууцанд орж, ипотекийн зээлд хамрагдав.

“Тод онош” эмнэлзүйн лабораторын Зул бадам төслийн урилгаар Хөвсгөл аймагт ажиллах хугацаанд улсын бүртгэлийн хэлтсийн нийт 22 албан хаагч Хөвсгөл аймагт хийгдэдгүй хеликобактерийг амьсгалаар тоолох шинжилгээ болон хавдрын маркерын шинжилгээнд хамрагдаж зөвлөгөө мэдээллэл авав.

2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Эрүүл мэндийн сургагч багш Г.Дашжаргалыг урьж хэлтсийн албан хаагчдад эрүүл зөв амьдралын хэвшил олгох, эрүүл зөв хооллох талаар “Эрүүл аж төрөх соёл” сэдэвт сургалтанд хамрууллаа.

Рэнчинлхүмбэ сум, Тариалан сум, Цагаан-Уул сум, Улаан-Уул, Жаргалант, Эрдэнэбулган, Шинэ-Идэр зэрэг сумын улсын бүртгэгч нарыг тухайн сумын Засаг даргын тамгын газрын нэгдсэн зохион байгуулалттайгаар Улаанбаатар хот дахь Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг, Орхон аймгийн Эрдэнэт Медипас эмнэлэгүүдэд хийгдэж буй эрүүл мэндийн бүтэн биеийн оношлогоо, шинжилгээнд хамрагдахад 5 хүртэл хоногийн чалинтай чөлөө олгож мөн албан хаагчдийн хүсэлтийн дагуу эмчлүүлэх зайлшгүй шаардлагатай тусламж шаардлагатай бага насны хүүхэд албан хаагчдад эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, болон богино хугацааны цалинтай чөлөөг чөлөөний хуудсаар олгож үүрэгт ажлыг нь бусад албан хаагчаар давхар гүйцэтгүүлэх байдлаар зохицуулалт хийж ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Энэ жилдээ Эрүүл жиндээ-2- арга хэмжээний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Хөвсгөл аймгийн биеийн тамирын спортын газрын Нийтийн биеийн тамирын арга зүйч Б.Батаа, Б.Пагамдулам нарыг урьж хэлтсийн 20 албан хаагчийн биеийн тэнцвэр, хурд хүчний сорил авч, биеийн жингийн индекс тооцуулж, биед гарсан өөрчлөлтийн талаарх зөвлөгөө мэдээллэл авав.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/96 дугаар захирамжийн хүрээнд “Хөвсгөл Марафон-2024” улсын уралдааныг Мөрөн сумын Чингүнжавын талбайд 2024 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан бөгөөд тус хэлтсийн 6 албан хаагч 3 хүрэл медаль, 8,9,10 дугаар байр эзэлж амжилттай оролцов.

Хэлтэс нь албан хаагчдын дунд “Энэ жилдээ Эрүүл жиндээ-2” аяны хүрээнд зохион байгуулах арга хэмжээний удирдамжийг боловсруулан баталж 2024 оны 05 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд

- Ширээний теннис,
- Дартс шидэлт,
- Спорт өрөлт зэрэг тэмцээнүүдийг эрэгтэй, эмэгтэй ангилалд хувааж, бүх албан хаагчдыг ирц бүрэн хамруулан амжилттай зохион байгуулж, байр эзлүүлэв.

Баянзүрх сумын улсын бүртгэгч Н.Азжаргал, Тариалан сумын улсын бүртгэгч М.Номиндарь, Төмөрбулаг сумын улсын бүртгэгч Д.Пүрэвдорж, Цэцэрлэг сумын улсын бүртгэгч Д.Дэлгэрмөрөн, Чандмань-Өндөр сумын улсын бүртгэгч Т.Доньдмаа, Эрдэнэбулган сумын улсын бүртгэгч Э.Сосорбурам нар “Олон улсын гэр бүлийн өдөр” буюу 05 дугаар сарын 15-нд гэр бүлийн дунд зохион байгуулсан гар бөмбөг, олс таталт, АХА тэмцээн болон бүсийн албан хаагчдын тэмцээнд ЗДТГ-ын хамт олноороо амжилттай оролцсон байна.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Энэ жилдээ Эрүүл жиндээ-2- арга хэмжээний хүрээнд хэлтсийн бүх албан хаагчид 8 цаг 30 минутаас 09 цаг хүртэл өдөр бүр “Ажлын байрны дасгал”-г тогтмол хийж хэвшүүлэв.

Хэлтсийн даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Б/12 тоот “Мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалын дагуу төрийн захиргааны 27 албан хаагчид хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж болох 198.297.490 төгрөгийг олгосон.

УБЕГ-н даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/164 тоот тушаалаар улсын бүртгэлийн албан хаагчдад олгох хоол унааны нөхөн төлбөрийн хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 25000 төгрөгөөр тооцон олгож эхлэв.

Хөвсгөл аймгийн хэлтсийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн Б/01 “Ээлжийн амралт олгох тухай” тоот тушаалын дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 43 албан хаагчийн ээлжийн амралтын мэдэгдэл гаргаж амралтаа биеэр эдэлсэн бөгөөд ээлжийн амралтыг биеэр эдэлж чадаагүй албан хаагч байхгүй болно.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/16 тоот “Тэтгэмж олгох тухай” тушаалаар 2024 онд шинээр гэр бүл болж буй Галт сумын улсын бүртгэгч Д.Элбэгзаяа, Рашаант сумын улсын бүртгэгч Э.Энхбаяр нарт 300,000 төгрөг, гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол, Баянзүрх сумын улсын бүртгэгч Н.Азжаргал, Төмөрбулаг сумын улсын бүртгэгч Д.Пүрэвдорж, гэрээт жижүүр Р.Төмөрбаатар, гэрээт жижүүр Б.Зоригтбаатар нарт 100,000 төгрөгийг мөнгөн тэтгэмж олгосон байна.

3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Монгол улсын үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллалаа. Бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

2024 оны тайлант хугацаанд Төрсний бүртгэл 1815 үүнээс эрэгтэй 937, эмэгтэй 878, Гэрлэсний бүртгэл 354 үүнээс анхны гэрлэлт 305, дахин гэрлэлт 48 Гэрлэлт сэргээсний бүртгэл 1, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 135, үүнээс захиргааны журмаар 39, шүүхийн журмаар 96, Үрчилсний бүртгэл 38, Эцэг /эх/ тогтоосны бүртгэл 95, Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 80, нас барсны бүртгэл 743 бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Хяналтын улсын байцаагчийн 4865 дугаартай нэгдсэн дүгнэлтээр Төрсний бүртгэлийн 117, Үрчилсний бүртгэлийн 9, Овог, эцэг /эх/ийн нэр, өөийн нэр өөрчилсний бүртгэл 9, Эцэг /эх/ тогтоосны бүртгэл 17, гэрлэсний бүртгэл 12, Нас барсны бүртгэл 1 нийт 165 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Төрсний бүртгэлийн нөхөн бүртгэл 17, Овог, эцэг /эх/ийн нэр, өөрийн нэр өөрчилсний нөхөн бүртгэл 1, гэрлэсний нөхөн бүртгэл 32, гэрлэлт дуусгавар болсны нөхөн бүртгэл 1, нас барсны бүртгэлийн нөхөн бүртгэл 1 нийт 52 бүртгэл нөхөн бүртгэсэн байна. Мөн нэрийн сангийн өөрчлөлтөөр 16 бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 15 иргэний регистрийн дугаарыг ИУБ-25 маягтаар өөрчлөн бүртгэлийг мэдээллийн санд оруулсан.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн нэрийн санд гэрлэлтийн төлөв өөрчлөх 60 иргэний хүсэлтийг хүлээн авч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалган хяналтын улсын байцаагчийн 6839 дугаартай нэгдсэн дүгнэлтээр төлөв өөрчилсөн байна.

Иргэний улсын бүртгэлийн /ИУБ/ маягтуудыг үсгийн дарааллар галиглан УБЕГ-ын нэгдсэн архивт /А/ талыг, Б" талыг иргэний баримтын архивт жагсаалтын хамт хүргүүлэн баяжилт хийсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж чиглэлийг тухайн цаг бүрт сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хоёр. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

2024 оны тайлант хугацаанд бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 687 бүртгэл үүнээс насанд хүрсэн 425, хүүхэд /16-аас доош насны/ 262, сум хооронд шилжин ирсэн 1309 бүртгэл үүнээс насанд хүрсэн 788 хүүхэд /16-аас доош насны / 521, баг хооронд шилжин ирсэн 1689 бүртгэл үүнээс насанд хүрсэн 919, хүүхэд /16-аас доош насны/ 770 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоохтой холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 4-р сарын 16-ны 1/4924 дугаартай “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичиг, Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11-р сарын 16 ны өдрийн 3/10685 “Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” чиглэлийн хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд тогтмол хяналт тавин ажиллаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 4-р сарын 25 ны өдрийн А/61 тушаалын дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоон, бүртгэлд хяналт тавин ажилласан байна.

Иргэний баримтын архивт хадгалагдаж байгаа тодорхойгүй төлөвтэй 1100 иргэний хувийн хэргийг мэдээллийн санд шалгаж нийслэл болон бусад аймгийн хаягтай 637 иргэний ХААТР-11 маягт болон хувийн хэргийг харьяа аймаг нийлэлийн улсын бүртгэлийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн ба манай аймгийн хаягтай 463 иргэний хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийж ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 2020-2023 оны иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг мэдээллийн сантай тулган шалгаж ажилласан байна.

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/111 дугаартай “Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай” тушаалын дагуу бүртгэлийг сэргээж иргэний баримтын архивт хадгалагдаж байсан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, үнэт цаас /ИУБ-22/-ыг тухайн сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоох тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/128 дугаар тушаал гарсантай холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ИУБ-22 маягт, бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэхийг шалгалаа.

Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia.mn/-ээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд хүсэлт илгээсэн 27 иргэний хүсэлтийг шалгаж, 4 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж, 23 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг татгалзаж тухайн иргэдэд утсаар мэдэгдэж сумын улсын бүртгэгч бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөж ажиллалаа. Үүрэг чиглэлд заасан хугацаанд 2024 оны 08 дугаар сарын 09-ны 18 цаг 00 минутад өөрийн харъяалах нэгжийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хааж, хаасан тухай бүртгэлийн дэвтэрт сумдын улсын бүртгэгч нараар тэмдэглэл үйлдүүлэн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын алхах бүртгэгч, бүртгэгч нарын хамт сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэр, үлдэгдэл үнэт цаасыг 2024 оны 08 дугаар сарын 09-12-ны хооронд татан авах арга хэмжээ зохион байгуулж ИУБ-22 маягтын үлдэгдэлийг жагсаалт гарган акт үйлдэж лацдан иргэний баримтын архивт хадгаллаа.

Тус хугацаанд Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийт 1888 бүртгэл хийж баталгаажсан бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний 746 бүртгэлийг цаг хугацаанд нь бүртгэж, баталгаажуулан, цахимжуулалтад тухай бүр тогтмол хяналт тавин ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/170 дугаартай "Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай" тушаалын дагуу бүртгэлийг сэргээж иргэний баримтын архивт хадгалагдаж байсан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, үнэт цаас /ИУБ-22/-ыг тухайн сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Гурав.Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:

Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 6740 бүртгэл үүнээс шинэ 2094, хаяж үрэгдүүлсэн 2036, дүр төрхийн өөрчлөлт орсон 2, хорин таван насны сунгалт хийлгэсэн 1075, дөчин таван насны сунгалт 1530 бүртгэл хийгдэж 4702 иргэний цахим үнэмлэх хэвлэгдэн, иргэдэд олгогдсон байна.

Шинээр иргэний үнэмлэх авах насанд хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насанд хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж ИШБүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

УБЕГазар, ИУБГазраас иргэний үнэмлэхийн бүртгэл, биеийн давхцахгүй өгөгдөл /ИУБ31/ бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэлийг цаг тухай бүрт сумдын улсын бүртгэгч нарт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Хурууны хээ давхардсан, зөрсөн 6 иргэний бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилгуулахаар ИУБГазарт хүргүүлсэн байна.

2024 оны тайлант хугацаанд бүртгэл хөтөлсөн 4702 ИУБ-31 маягтын А талыг УБЕГ-ын улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлсэн бөгөөд Б талыг иргэний баримтын архивт хүлээлгэн өгч баяжилт хийгдсэн байна.

Дөрөв. Гадаад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:

Үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажлын хүрээнд нийт шинээр 6921 иргэний гадаад паспортын захиалга авч, 6798 хүсэлтэд Е дугаар бичин 6798 хуудас сканнердаж мэдээллийн санд цахимжуулсан байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтын бүртгэл 682 бүртгэгдсэн байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн эрхийг тодорхой сумын улсын бүртгэгч нарт үе шаттайгаар олгох зорилгоор Цэцэрлэг, Цагаан-Уул, Тариалан, Их-Уул сумын засаг дарга нарт албан бичиг хүргүүлэн стандартын шаардлага хангасан зургийн аппарат, гэрэлтүүлэг, зэргийг сумын төсвөөс шийдвэрлэж өгөх хүсэлт гарган хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн тухайн сумын улсын бүртгэгч нарт гадаад паспортын болон зураг засварын программын дадлага олгон ажиллаж 2024 оны 3 дугаар сарын 14-ний өдөр “ГЭРТ ОЙР, ГАРТ ОЙР ГАДААД ПАСПОРТ” уриатай гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг сумаасаа авах үйл ажилагааг албан ёсор нээж бүртгэлийн үйлчилгээг иргэн бүрт улам ойр болгон ажиллаж байна. Мөн Эрдэнэбулган, Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ, ИТХ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд Үндэсний гадаад паспортын бүртгэлийн тоног төхөөрөмж шийдвэрлэж 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрөөс 07 дугаар сарын 26-ны өдрийн хооронд Эрдэнэбулган сумын Улсын бүртгэгч Э.Сосорбурам, 2024 оны 10 дугаар сарын 28-аас 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд Рэнчинлхүмбэ сумын улсын бүртгэгч П.Оргилсайхан нар Улсын бүртгэлийн хэлтэст үндэсний энгийн гадаад паспортыг бүртгэл хөтлөх дадлага хийж гадаад паспортын бүртгэлийг тухайн сумандаа хөтлөн ажиллаж байна.

2024 оны тайлант хугацаанд Цэцэрлэг суманд 102, Цагаан-Уул суманд 85, Их-Уул суманд 102, Тариалан суманд 165, Эрдэнэбулган суманд 21 гадаад паспортын бүртгэл нийт 475 иргэний гадаад паспортын бүртгэл хөтөлсөн байна.

Хилийн бүс нутаг болох Ханх, Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумын ЗДТГазар, ИТХуралтай хамтран 2024 оны 1 дүгээр сарын 16-17-ны өдөр үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж 237 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай хүргэсэн байна.

Эрдэнэбулган сумын ИТХурал, ЗДТГазрын хүсэлтээр тус суманд 2024 оны 03 дугаар сарын 16-ны өдөр ажиллаж 90 иргэнд гадаад паспортын үйлчилгээг үзүүлэн ажилласан байна.

ОХУ, Монгол улсын хил хуваагдсан цагаас хойш ОХУ-н Тува улс дахь тож хошуун дахь төрөл төрөгсөд, ахан дүүстэйгээ 60-70 жил уулзаагүй цаатан иргэдийг ахан дүүстэйгээ уулзах боломжийг бүрдүүлэх зорилгоор аймгийн төв орж гадаад паспорт захиалах боломжгүй цаатан иргэдэд 2024 оны 4-р сарын 13 наас 15 ны өдрүүдэд хүрч үйлчлэн “ЦААТНЫ УРЦАНД ЦАХИМ ГАДААД ПАСПОРТ” өдөрлөгийг зохион байгуулан 106 иргэд гадаад паспортын үйлчилгээг үзүүлсэн бөгөөд Улсын чанартай “МОНЦАМЭ” агентлаг, UBS телевиз, ТУ5 телевизээр мэдээлэл цацагдсан болно.

Тав. Монгол Улсын Их Хурлын сонгууль болон Аймаг, Нийслэл, Сүм, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу Хөвсгөл аймгийн 23 сумын сонгуулийн хэсэг байгуулах тухай сумдын ИТХ тогтоолыг хуулийн хугацаанд нь хүлээн авч цахимжуулан, улсын бүртгэлийн мэдээллийн санд хэсгийн төв санал авах байрыг шивж оруулан тогтоолын эх хувийг Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг холбогдох хууль, журмын хүрээнд нятлан шалгаж 2024 оны 05 дугаар сарын 30-ний өдөр хэвлэн хуулийн хугацаанд хэсгийн хороодод хүлээлгэн өгч ажилласан.

Улсын бүртгэлийн байгууллагын 129 хэсгийн хороонд ажиллах 132 итгэмжлэгдсэн ажилтанд ирц бүртгэлийн программын болон эрх зүйн сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 19-нд зохион байгуулсан. Сургалтын хөтөлбөрт заасны дагуу компьютер, техник тоног төхөөрөмж, кодыг, итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгч, сервер болон клиент компьютерүүдийг сүлжээгээр холбон, модем шалгах, IP хаяг, системийн цагийг тохируулж программын дадлага хийлгэсэн. Мөн СНЖ-ын программыг акт үйлдэн түгжиж, битүүмжлэн лацдах ажлыг зохион байгуулж 129 хэсгийн 141 компьютер, хэвлэх төхөрөөмжийг тус аймгийн Тагнуулын хэлтэст хүлээлгэн өглөө.

2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/109 дугаар тушаалын дагуу “Удирдлагын шуурхай баг”-ийн хуваарь /06.00-23.00 цаг/ гарган дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа: Үүнд:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлж санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан асуудал, мэдээллийг шуурхай багийн хуваарийн дагуу хариуцсан албан хаагчтай холбогдож итгэмжлэгдсэн ажилтан хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж, чиглэл, зөвлөмж өгч арга зүйгээр ханган Мэдээлэл технологийн газраас өгсөн гарын авлага, анхааруулга, санамжийг 132 итгэмжлэгдсэн ажилтанд сумдын улсын бүртгэгч нар хэвлэн өгч, танилцсан эсэхийг шуурхай багийн гишүүд утсаар нэг бүрчлэн холбогдон асууж дахин нэмэлт мэдээлэл өгч ажиллалаа.

Сонгуулийн хэсгийн хорооны сервер, клиент компьютерийн сүлжээний холболт, пинг шалгах, модем сүлжээ хэвийн эсэх, бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг шалган, сонгуулийн үйл ажиллагаа хуульд заасан хугацаанд амжилттай эхэлсэн. Сонгогчийн ирцийн мэдээг тухай бүр мэдээг илгээх, илгээгээгүй сонгогчийн мэдээг байнга тулган шалгаж тогтмол итгэмжлэгдсэн ажилтантай холбоо барьж Монгол Улсын Их хурлын сонгуулийг амжилттай зохион байгуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуультай холбоотойгоор улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд тусгагдсан цагалбарын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ИУБ-22 маягт, бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэхийг шалгалаа. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia.mn/-ээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд хүсэлт илгээсэн 27 иргэний хүсэлтийг шалгаж, 4 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж, 23 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг татгалзаж тухайн иргэдэд утсаар мэдэгдэж сумын улсын бүртгэгч бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтөлж ажиллалаа.

Үүрэг чиглэлд заасан хугацаанд 2024 оны 08 дугаар сарын 09-ны 18 цаг 00 минутад өөрийн харъяалах нэгжийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хааж, хаасан тухай бүртгэлийн дэвтэрт сумдын улсын бүртгэгч нараар тэмдэглэл үйлдүүлэн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын алхах бүртгэгч, бүртгэгч нарын хамт сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэр, үлдэгдэл үнэт цаасыг 2024 оны 08 дугаар сарын 09-12-ны хооронд татан авах арга хэмжээ зохион байгуулж ИУБ-22 маягтын үлдэгдэлийг жагсаалт гарган акт үйлдэж лацдан иргэний баримтын архивт хадгаллаа.

Тус хугацаанд Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийт 1888 бүртгэл хийж баталгаажсан бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний 746 бүртгэлийг цаг хугацаанд нь бүртгэж, баталгаажуулан, цахимжуулалтад тухай бүр тогтмол хяналт тавин ажиллалаа.

СНЖ-ыг сонгогчийн программаас сонгогчдын нэрийн жагсаалтыг хуваарийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 09 цаг 30 минутаас эхлэн 2 хувь хэвлэн хуудас тус бүрээр нягтлан шалгаж хэлстийн дарга болон хэвлэсэн улсын бүртгэгчээр гарын үсэг, тамга дарж баталгаажууллаа. Хэвлэх явцад ямар нэгэн алдаа зөрчил илэрсэнгүй. СНЖ-ын 1 хувийг хэлтэст авч үлдэн, 1 хувийг сумын сонгуулийн хорооны дарга болон итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгөхөөр 6-н хэсэгт хуваагдан 21 сум 131 хэсэгт амжилттай хүлээлгэн өглөө. Мөн нийт 129 хэсгийн хорооны 131 итгэмжлэгдсэн ажилтны нууцын баталгааг гарын үсэг зуруулан, хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, итгэмжлэгдсэн ажилтаны үнэмлэх гардуулан өгч, АНСДИТХ-ын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмыг хэвлэн дахин танилцуулж ажиллалаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан нарт программын болон иргэний улсын бүртгэлийн сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 29-нд зохион байгууллаа. Тус аймгийн 129 хэсгийн хорооны 131 итгэмжлэгдсэн ажилтан болон хэлтсийн ажилтан, албан хаагч бүрэн хамрагдсан. Сургалтын хөтөлбөрт заасны дагуу компьютер, техник тоног төхөөрөмж, кодыг, итгэмжлэгдсэн ажилтанд хүлээлгэн өгч, сервер болон клиент компьютерүүдийг сүлжээгээр холбон, модем шалгах, IP хаяг, системийн цагийг тохируулж программын дадлага хийлгэлээ.

2024 оны 10 дугаар сарын 1-11-ний өдөр хүртэл хэлтсийн даргаар батлуулсан “Шуурхай баг”-ийн хуваарь гарган дараах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн иргэдийн Төлөөлөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлж санал авах өдөр сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан асуудал, мэдээллийг шуурхай багийн хуваарийн дагуу хариуцсан албан хаагчтай холбогдож итгэмжлэгдсэн ажилтан хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж, чиглэл, зөвлөмж өгч арга зүйгээр тогтмол ханган ажиллалаа.

Сонгуулийн өдөр хийх ажлын гарын авлага, анхааруулга, санамжийг 131 итгэмжлэгдсэн ажилтанд болон сумдын улсын бүртгэгч нар хэвлэн өгч тарааж танилцсан эсэхийг шуурхай багийн гишүүд утсаар нэг бүрчлэн холбогдож асууж дахин нэмэлт мэдээлэл өгч, сонгуулийн хэсгийн хорооны сервер, клиент компьютерийн сүлжээний холболт, пинг шалгах, модем, старлинк сүлжээ хэвийн эсэх, бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, моторын аюулгүй хэвийн ажиллагааг хангаж хамтарч ажиллах тухай тус аймгийн сонгуулийн хороонд болон сумын хэсгийн хороонд албан тоот хүргүүлэн ажиллалаа.

Сонгогчийн ирцийн мэдээг тухай бүр мэдээг илгээх, илгээгээгүй сонгогчийн мэдээг байнга тулган шалгаж тогтмол илгээх талаар шуурхай багийн албан хаагч итгэмжлэгдсэн ажилтантай тухай бүр холбоо барьж ажиллалаа.

Сонгуулийн хэсгийн хорооны старлинг болон бусад тоног төхөөрөмж, итгэмжлэгдсэн ажилтаны ирц бэлэн байдлыг өглөөний 05 цагаас эхлэн утасдан шалгаж 07:00 минутад 129 хэсгийн хороо амжилттай нээлтийн тайланг хэвлэж эхлэн зөөврийн хайрцагаар санал авсан иргэдийн мэдээллийг бүрэн уншуулж ирц бүртгэлийн явц хэвийн үргэлжилсээр 20:00 минутад хаалтын тайланг хэсэг тус бүрээр авч УБЕГ-ын хяналтын программын тоотой тулган шалгахад зөрчил илэрсэнгүй тоон мэдээ таарлаа.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, 24.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын А/170 дугаартай "Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай" тушаалын дагуу бүртгэлийг сэргээж иргэний баримтын архивт хадгалагдаж байсан иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, үнэт цаас /ИУБ-22/-ыг тухайн сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Зургаа. Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагаа, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн "Нээлттэй" мэдээллийг иргэдэд 11360, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 2190, албан хэрэгцээнд 2591 лавлагааг олгож иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 11657 ИУБ маягтуудын баяжилт хийж хураасан бөгөөд үүнд Төрсний бүртгэл /ИУБ-11/ 1815, Үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 38, Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 80, Эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 95, Гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 354, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 135, Нас барсны бүртгэл /ИУБ-18/ 743, Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл /ИУБ-31/ 4702, шилжин ирсний бүртгэл /ИУБ-22/ 3454, бусад аймаг хотод бүртгэл хийлгэсэн, шилжин ирсэн 241 иргэдийн хувийн хэргийг иргэний баримтын архивт баяжилт хийсэн байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5д заасны дагуу иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 24 сумын улсын бүртгэгчээс татан авч хадгаламжийн нэгж, 2023 оны бүртгэлийн 308 дэвтэр болон бүрдүүлбэрийг хадгалалтын стандартын шаардлагын дагуу хүлээн авч архивт баяжилт хийсэн байна.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний болон эцэг, эхийн мэдээлэл зөрсөн болон зөрчилтэй 188 иргэний ХААТР, ИУБ маягт, холбогдох бүртгэлийн дэвтрийн хуулбарыг мөн тухайн бүртгэлтэй холбоотой дэвтэр шүүж зөрчил арилгуулахаар улсын бүртгэгч Б.Дуламсүрэнд хүлээлгэн өгч зөрчил арилган ажилласан байна.

Архивын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгууллагын болон иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтын жагсаалтыг гаргаж ББНШК-ын хурлаар хэлэлцэж 14 нэр төрлийн баримт, ИУБ-21, ИУБ-22 маягтыг устгах саналыг УБНА-ын газарт хүргүүлж ажиллалаа.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн сан болон ИГБББ-ийн дэвтэрүүдийг сэлбэн засаж, хувийн хэргийн санд хадгалагдах иргэдийн хувийн хэргийг тус бүр дугтуйлж, зориулалтын хайрцагт бичилт хийж тавиурт галигийн дагуу байршуулж байна.

Долоо. Цахим гарын үсэг олгох ажлын хүрээнд:

Цахим гарын үсгийн тухай хууль, улсын бүртгэлийн байгууллагаас Монгол улсын 16 насанд хүрсэн иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хүрээнд аймгийн Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын 30 албан хаагч, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төв”- 15 албан хаагч, Хөвсгөл аймгийн Засаг даргын санаачилсан “ИРГЭДЭЭ СОНСЪЁ” өдөрлөгт 40 иргэнд, Хуульчдын “Про боно” өдөрлөгт 10 иргэнд, сумдын “ХААН БАНК”-наас үйлчилгээ авч байгаа 254 иргэн, цахим гарын үсгийн тухай хууль, холбогдох журмын талаар мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар тухайн сумынхаа ЗДТГазартай хамтран нийт төрийн албан хаагчид болон иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн мэдээлэл өгөх тоон үсэг олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд тоон гарын үсэг авах 90464 иргэнээс өнгөрсөн оны тайлант хугацаанд 51488 иргэнд буюу 57%-тай байсан бол 2024 оны тайлант хугацаанд **20973** иргэнд тоон гарын үсэг олгож, нийт **72461** иргэнд тоон гарын үсэг олгож, тоон гарын үсэг олгох ажил **80.09%**-тай явагдаж байна.

Найм. Ил тод байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд:

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгчид 2024 онд 16 нас хүрч иргэний үнэмлэх авах, 25 ба 45 насны сунгалт хийлгэх иргэдийн судлагааг гаргаж багийн засаг дарга нартай хамтран хуулийн хугацаанд бүртгэлд хамруулах ажлыг жил бүр уламжлал болгон зохион байгуулан ажиллаж байна.



Аймгийн Засаг даргын санаачилгаар 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан “ИРГЭДЭЭ СОНСЪЁ” өдөрлөг орлцож 43 иргэнд тоон гарын үсэг олгож, 5 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Иргэний эрх зүйн боловсролыг дэмжих зорилгоор жил бүр 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг Хуульчдын “Про боно” өдөрлөгт оролцож Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ болон тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан байна.


“Улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтан ажил эрчимжүүлэх үйл ажиллагааны удирдамж” гарган тус хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд удирдамжийн хүрээнд Баянзүрх, Галт сумын Д.Элбэгзаяа, Арбулаг сумын улсын бүртгэгч А.Батцэнгэл, тариалан сумын улсын бүртгэгч М.Номиндарь нар өөрийн биеэр ирж бүртгэлийн үйлчилгээ авах боломжгүй хэвтрийн болон асаргаанд байдаг 27 иргэнд зөөвийн сүлжээний төхөөрөмжөөр хүрч үйлчлэн Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл /ИУБ-31/, Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл /ИУБ-22/, Иргэний улсын бүртгэлийн лавлагаа, Тоон гарын үсэг олголт зэрэг бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн Жаргалант сумын улсын бүртгэгч Ө.Түвшинсайхан тус сумын ЕБС-ийн 11-р ангийн сурагчид болон эрүүл мэндийн төвийн ажилтан П.Даваажаргалын иргэний үнэмлэхийг хүлээлгэн өгч иргэний цахим үнэмлэх олголтын бүртгэл хөтлөсөн байна.

“Улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтан ажил эрчимжүүлэх үйл ажиллагааны удирдамж”-н үйл ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 24 өөс 2024 оны 11 дүгээр сарын 30 ны өдрийг дуустал зохион байгуулах бөгөөд Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны улсын бүртгэгч нар үе шаттайгаар үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн “Улсын бүртгэлийн ажилтны өдөр” ийг угтан улсын бүртгэлийн хэлтсийн 101 тоот өрөөний тохижилтыг сайжруулан ханын зураг зуруулан мөн шинэ төрсөн хүүхэд бүртгүүлэхээр хүүхэдтэйгээ ирсэн эцэг, эхчүүд хүүхдээ унтуулах, хуурайлах орчинг тохижуулан ажилласан.


Ес. Иргэний улсын бүртгэлийн сүүлийн 3 жилийн судалгааг графикаар харуулав



Иргэний үндэсний энгийн гадаад паспорт



Иргэний баримтын архивын баяжилт



	2022 он	2023 он	2024 он
■ ИУБ-11, ИУБ-12, ИУБ-13, ИУБ-14, ИУБ-15, ИУБ-16, ИУБ-18	2145	3771	3260
■ 16 нас хүрч ШБ-д хамрагдсан иргэд	1957	1836	2093
■ 25 болон 45 насны сунгалт	3193	2683	2608
■ шилжилт хөдөлгөөний бүртгэл	638	726	3685

4. ЭД ХӨРӨНГӨ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль, Хоршооны тухай хууль, Компаний тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын засгийн газрын 2020.12.23-ны өдрийн 230 дугаар тогтоол, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэн ажиллалаа. 2024 оны эхний хагас жилд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт **13416** мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажилласан ба хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **1066** материал хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна.

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал 3, үүрэг, чиглэл 1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын тамгын газрын даргаас ирүүлсэн 2 чиглэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 6 чиглэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 7 чиглэл зөвлөмж, Хяналтын улсын байцаагчийн 1 мэдэгдлийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчийн “Зөрчил арилгах тухай” 05 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

НЭГ. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэдээс “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д заасан шалтгаанаар хувийн хэрэг хаалгахаар ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичиг, мэдүүлгийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 24, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 4 хувийн хэрэг бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 8 дугаар сарын А/1614 дугаар тушаалаар тус тус хаасан байна. Мөн иргэн хуулийн этгээдээс үрэгдүүлсэн гэрчилгээг дахин авах тухай өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцуулж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 21, газар өмчлөх эрхийн 25 гэрчилгээг дахин олгож ажиллалаа.


Тайлант хугацаанд бүртгэсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг төрөл тус бүрээр ангилан авч үзвэл:

1.1 Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх:


Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт 187 бүртгэл бүртгэснээс 166 нь төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх, 21 нь өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх бүртгэл байна. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **977** бүртгэсэн үүнээс өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 86, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 312, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх 579 тус тус бүртгэж, нийт **1164** хувийн хэрэг шинээр үүсгэн архивт байрлуулсан байна.



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:





Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



1.2. Барьцааны бүртгэл /ипотек/:


Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн барьцааны бүртгэлийн **6495** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцаалбартай барьцааны гэрээ **1918**, барьцаалбаргүй барьцааны гэрээ **1259**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **61**, барьцааны гэрээ дуусгавар болгох **3251** тус тус хүлээн авч бүртгэсэн.

Мөн газар өмчлөх эрхийн барьцааны бүртгэлийн **3442** мэдүүлэг хүлээн авсан ба үүнээс барьцаалбаргүй барьцааны гэрээ **1635**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **9**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1791**-г тус тус хүлээн авч бүртгэсэн байна.




1.3. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх:

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл **993**, газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэл **600** нийт **1593** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хөтөлсөн байна. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр **134**, ХХАГ-ээр **1068**, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх **208**, хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр **168**, өмчлөгчийн үүсгэн байгуулсан ХЭ-ээс иргэнд, иргэн үүсгэн байгуулсан ХЭ-ийн өмчлөлд өмчлөх эрх шилжих **9**, өмчлөх эрх шилжүүлэх гэрээгээр **1**, арилжааны гэрээгээр **3**, шүүхийн шийдвэр өмчлөгч өөрчлөгдөх **1**, өмчлөгчийн овог нэр өөрчлөгдөх **1** бүртгэл тус тус бүртгэсэн байна.




1.4. Эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах **683** мэдүүлэг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн байна. Үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр олгох **46**, гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох **17**, эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх **235**, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх **17**, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх **341**, газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх **23**-г тус тус бүртгэж, холбогдох материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа.



1.5. Лавлагаа хуулбар олголт:

Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт **2447** лавлагаа, **5** хуулбар олгосон байна.



1.6. Бусад бүртгэл:

2024 оны тайлант хугацаанд урьчилсан тэмдэглэл хийх бүртгэл 15, урьчилсан тэмдэглэл хүчингүй болгох бүртгэл 9, түрээсийн гэрээ 10г тус тус бүртгэсэн байна. Мөн Монголын Ипотекийн корпораци ОССК /МИК/-аас цахимаар илгээсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн 32 мэдүүлэг хүлээн авч 2 мэдүүлгийг татгалзаж, 30 барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг бүртгэсэн байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 5/13341 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн “Голомт банк”ХК-иас барьцаат зэлийн гэрээ бүртгүүлэх, барьцааны гэрээ дуусгавар болгох үйлчилгээний нотлох баримтыг нотариатчаас улсын бүртгэлийн үйлчилгээг зуучлах, мэдүүлэг гаргагчийн улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг хуулийн шаардлага хангуулан мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр тус тус дундын мэдээллийн сангаар дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимаар илгээж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Хөвсгөл аймгийн хэмжээнд цахимаар илгээсэн хүсэлт байхгүй байна.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:


2.1. Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:

2024 оны тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулах хуулийн этгээдийн **614** материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэн, хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өгч ажиллалаа. Шинээр хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын **896** хүсэлт шийдвэрлэсэн байна


Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг төрлөөр нь ангилбал:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани -**252**,
- Хоршоо -**338**,
- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар-**2**
- Төрийн бус байгууллага /НҮТББ/ -**12**
- Төрийн бус байгууллага /ГҮТББ/ -**4**
- Нөхөрлөл-**1**
- Улсын төсөвт үйлдвэрийн газар - **1**
- Төрийн байгууллага албан газар - **4**-ыг газрыг тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.


Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Шинээр үүсгэн байгуулсан Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Шинээр үүсгэн байгуулсан Хоршооны бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:





Мөн e.business.mn-ээр нийт 1247 нэрийн баталгаажилтын хүсэлт, болон 2 хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүртгэл хийлгэх хүсэлтийг шийдвэрлэсэн байна.

2.2 Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл **452** хүлээн авч холбогдох бүртгэлийг хөтлөн, хувийн хэрэгт баяжилт хийсэн байна. Үүнээс:

- Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар **71**,
- Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон худалдах, худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл дүрмийн сан, гишүүн нэмэх хасах бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан **373**
- татан буугдсан **8** хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өглөө.






2.3 Хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар:

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр **112** лавлагаа, **33** хуулбар олгосон байна.



2.4 Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих:

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу **614** хуулийн этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож 2024 оны тайлант хугацаанд татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан **45** ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгэнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.



ГУРАВ. АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж, 2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Хэлтсийн даргаар батлуулан, төлөвлөгөөнд тусгагдсан 8 үйл ажиллагааны биелэлтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 19638, газар өмчлөх эрхийн 13438, нийт 33076 хувийн хадгалагдаж байна. Үүнээс 2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр 1164 хувийн хэрэг нээж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хүлээн авч байрлуулсан ба 13441 хувийн хэрэгт баяжилт хийсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт 2024 оны тайлант хугацаанд цахим санд бүртгэлтэй 3649, татан буугдсан 331, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 хувийн хэрэг байршиж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 614 шинэ хувийн хэрэг нээж хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт байрлуулсан ба 452 хувийн хэрэгт баяжилт, тэмдэглэгээг хийж архивт буцаан байрлуулсан.


Тайлант хугацаанд Хяналтын улсын байцаагчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1098 хувийн хэрэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 193 хувийн хэргийг тус тус татаж шалгуулан хувийн хэргийг буцаан байрлуулсан.

2024 оны 1,2,3 дугаар улиралд олгосон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагааны мэдүүлэг нотлох баримтыг 250 нэгжээр баримт үүсгэн үдэн архивын санд байршуулсан байна.


2024 онд Хөвсгөл аймаг шинээр баригдаж ашиглалтанд орсон нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээний зориулалттай 5 үл хөдлөх эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, нотлох баримтуудыг нягтлан шалгаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн систем /eprs/-д цахимжуулж, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газраас олгосон хаягийн дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд хаяг нэмж оруулан хувийн хэрэг үүсгэн улсын бүртгэлийн “Ж” дугаар олгож архивт хүлээлгэн өгсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудын судалгаа гаргаж ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн устгах саналыг УБЕГ-ын Нэгдсэн архивын газарт хүргүүлэн ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын хувийн хэргийн тоог сүүлийн 3 жилээр харьцуулбал



Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хувийн хэргийн тоог сүүлийн 3 жилээр харьцуулбал



ДӨРӨВ. МЭДЭЭ ТАЙЛАН, ХУГАЦААТАЙ АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт тус тус хүргүүлж ажиллалаа. Улсын бүртгэгч нар гэрчилгээ болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж хэлтсийн ахлах нягтлан бодогчоор хянуулж тооцоо нийлэн ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын газар, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой **202**, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн **68** албан бичгийн хариу лавлагаа мэдээллийг хугацаанд хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг тогтоол шийдвэрийн дагуу **121** эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, **83** эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон байна. Хуулийн этгээдийн бүртгэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн тогтоолоор хориг тавьсан **3**, хориг цуцалсан **3** бүртгэл хийж хариу хүргүүлсэн байна. Мөн МИК-АКТИВ-34,35 ТЗК ХХК болон ҮЦСК ХХК-ийн хүсэлтийн дагуу **114** эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, ҮЦСК-ийн хүсэлтийн дагуу **7** эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгож бүртгэлээ.

ТАВ. ТЭМДЭГТИЙН ХУРААМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ТАЛААР:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 13442 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээгээр 132 307 272 /зуун гучин хоёр сая гурван зуун долоон мянга, хоёр зуун далан хоёр/ төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлсэн ба үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсны 2 хувь 645 088 583 /зургаан зуун дөчин таван сая, наян найман мянга, таван зуун наян гурван/ төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө анх удаа бүртгүүлсний тэмдэгтийн хураамжинд 10 597 166 /арван сая таван зуун ерөн долоон мянга нэг зуун жаран зургаан/ төгрөгийг тус тус татварын орлогод төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр тамга, тэмдгийн хяналтын дугаар болон нэрийн баталгаажуулалт, дахин гэрчилгээ, лавлагаа, хуулбарын үйлчилгээний хураамж 23 573 000 /хорин гурван сая таван зуун далан гурван мянган/ төгрөгийн мөнгөн орлогыг үйлчилгээний орлогод төвлөрүүлсэн ба тэмдэгтийн хураамжийн 26 972 000 /хорин зургаан сая есөн зуун далан хоёр мянган/ төгрөгийг татварын орлогод төвлөрүүлсэн байна.

Тус хэлтэс нь “Гэрэгэ” пос машин, “Киоск” машинаар тус тус үйлчилгээний хураамжийг авч иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж байна.

5. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч нь улсын бүртгэлийн алдаа, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн байгууллагын ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавин ажиллахаас гадна алдаа зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, улсын бүртгэлийн байгууллагын ажилтаны зөрчигдсөн эрх, ажил хэргийн нэр хүндийг сэргээх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн ажиллаж байна.

Нэг. Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасны дагуу улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн алдаа, зөрчлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох, арилгуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах зорилгоор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн хяналтын оператор өөрийн чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийх замаар алдаа, зөрчлийг илрүүлж ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд улсын алхах бүртгэгч, улсын бүртгэгч, улсын бүртгэлийн байгууллагын бусад ажилтан холбогдох эх нотлох баримт бичиг, жагсаалтыг гаргаж өгөх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий программ хангамж, техник, технологийн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүртгэлийн талаар нэмэлт мэдээлэл, тайлбар өгөх зэргээр хамтран ажиллалаа.

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын эх нотлох баримт бичигт тулгалт хийж, илрүүлсэн алдаа, зөрчлийн талаарх мэдээг сар бүр гарган, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж байна.

2024 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу **5102** бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Үүнээс:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-2530, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр-1068, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-228, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-1276 тус тус шалгаж ажиллалаа.

Тайлант хугацаанд иргэдээс өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалтаар: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-30, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-44, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-7, Улсын бүртгэлийн архивын чиглэлээр-0 тус тус зөрчил илэрсэн байна.

Хяналтын улсын байцаагчийн 81 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр-30, Хуулийн этгээдийн чиглэлээр-7, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр-44 дүгнэлт гарган ажилласан байна.

Зөрчлийн хуулиар 209 иргэн, хуулийн этгээдэд торгууль оногдуулсан бөгөөд Төрийн сангийн торгууль, хүү төвлөрүүлэх дансанд 4 240 000 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 1/655 дугаар үүрэг чиглэлийн дагуу мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хяналтын улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтнууд иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хөтлөх үйл ажиллагаанд холбогдуулан хяналтын улсын байцаагч нар өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх бүртгэлийг шалгаж ажиллалаа.

Энэхүү шалгалтыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүрэг, чиглэлд заасан ажлыг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллалаа.

Хууль, журам, албан тушаалын тодорхойлолтод заасан улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэлийн зөрчлийг гаргахгүй байх талаар нийт бүртгэгч нарт болон албан хаагчдад үүрэг даалгавар өгч ажиллалаа.



Хоёр. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр

2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу ажлын төлөвлөгөөний дагуу сонгуулийн хэсэг байгуулсан сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг хүлээн авч мэдээллийг үнэн зөв шивж, баталгаажуулж, цахимжуулсан эсэхийг нягтлан шалгаж засварлах арга хэмжээ авахад хяналт тавьж ажиллалаа.

Мөн Аймаг, Нийслэл, Сум Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хэсэг байгуулсан тухай мэдээллийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн бүртгэлтэй тулган шалгаж, сонгогчийн бүртгэлд бүртгэгдээгүй, сонгуулийн хэсэг оноогдоогүй болон иргэний улсын бүртгэлийн зөрчилтэй иргэний зөрчлийг арилгах, зөрүүтэй оноогдсон сонгогчдын мэдээллийг засварлаж хэсэг оноох ажилд хяналт тавин ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн иргэний улсын бүртгэлийн санд төрсөн он, сар, өдөр, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр ижил өөрийн харъяалагдах нэгжид хамаарах 230 иргэний мэдээллийг шалгаж хавсралтад дурдсан нэр бүхий иргэний тодорхойгүй бүртгэсэн төлөвтэйг Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган иргэний улсын бүртгэлийн тасагт өгсөн. Мөн Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн алдаатай төлөвтэй бүртгэгдсэн 11 иргэн, нас баралтын бүртгэлд давхар бүртгэгдсэн 8 иргэний мэдээллийг архивын эх нотлох баримттай тулган шалгаж, хүчингүй болгох тухай дүгнэлт гаргасан.

Үүрэг чиглэлд заасан хугацаанд өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн бүртгэлийн жагсаалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын алхах бүртгэгчтэй хамтран иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл бүртгэгдсэн эсэх нэг иргэн хоёр регистрийн дугаартай эсэхийг нотлох баримттай тулган шалгалаа.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр иргэдээс ирсэн өргөдөл, гомдол болон иргэний улсын бүртгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 30 дүгнэлт гаргаж Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж зөрчил арилгуулсан байна.

Дүгнэлтийн төрлөөр авч үзвэл:

- Нэмэлт өөрчлөлтөөр-3
- Регистрийн дугаар өөрчилж, дахин, шинээр олгох-13
- Бүртгэл хүчингүй болгох-6
- Бүртгэл сэргээх-1
- Регистрийн дугаар хүчингүй болгох-10

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дахь хэсэгт заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/61 дүгээр тушаал гарсантай холбогдуулан Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ИУБ-22 маягт, бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэхийг шалгалаа. Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia.mn/-ээр 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд хүсэлт илгээсэн 81 иргэний хүсэлтийг шалгаж, 23 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж, 58 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг татгалзаж тухайн иргэдэд утсаар мэдэгдэж сумын улсын бүртгэгч бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөж ажиллалаа.


Үүрэг чиглэлд заасан хугацаанд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны 18 цаг 00 минутад өөрийн харъяалах нэгжийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хааж, хаасан тухай бүртгэлийн дэвтэрт сумдын улсын бүртгэгч нараар тэмдэглэл үйлдүүлэн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын алхах бүртгэгч, бүртгэгч нарын хамт сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэр, үлдэгдэл үнэт цаасыг 2024 оны 04 дүгээр сарын 26-29-ны хооронд татан авах арга хэмжээ зохион байгуулж ИУБ-22 маягтын үлдэгдэлийг жагсаалт гарган акт үйлдэж лацдан иргэний баримтын архивт хадгаллаа. Тус хугацаанд Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийт 1142 бүртгэл хийж баталгаажиж цахимжсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоох тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/128 дугаар тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ИУБ-22 маягт, бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэхийг шалгалаа.

Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-mongolia.mn/-ээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд хүсэлт илгээсэн 27 иргэний хүсэлтийг шалгаж, 4 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж, 23 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг татгалзаж тухайн иргэдэд утсаар мэдэгдэж сумын улсын бүртгэгч бүртгэлийн дэвтэрт тэмдэглэл хөтлөж ажиллалаа.

Үүрэг чиглэлд заасан хугацаанд 2024 оны 08 дугаар сарын 09-ны 18 цаг 00 минутад өөрийн харъяалах нэгжийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хааж, хаасан тухай бүртгэлийн дэвтэрт сумдын улсын бүртгэгч нараар тэмдэглэл үйлдүүлэн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын алхах бүртгэгч, бүртгэгч нарын хамт сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн дэвтэр, бүрдүүлбэр, үлдэгдэл үнэт цаасыг 2024 оны 08 дугаар сарын 09-12-ны хооронд татан авах арга хэмжээ зохион байгуулж ИУБ-22 маягтын үлдэгдэлийг жагсаалт гарган акт үйлдэж лацдан иргэний баримтын архивт хадгаллаа.

Тус хугацаанд Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр нийт 1888 бүртгэл хийж баталгаажсан бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 09-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний 746 бүртгэлийг цаг хугацаанд нь бүртгэж, баталгаажуулан, цахимжуулалтад тухай бүр тогтмол хяналт тавин ажиллалаа.



Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллалаа.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр өдөр тутмын болон түүвэрчилсэн, төлөвлөгөөт, улсын ахлах бүртгэгчээс ирүүлсэн өргөдөл зэрэг **1068** бүртгэлд хяналт шалгалт тавьж ажиллалаа.

Хяналтын улсын байцаагчийн нийт 44 дүгнэлт гаргасан бөгөөд үүнээс:

- Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох - 36
- Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай - 8

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 1068 бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт үнэн зөв эсэх, бичиг баримт бүрэн цахимжсаныг тулгаж шалгасан байна.



Дөрөв. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар **228** бүртгэлийг мэдээллийн санд эх нотлох баримт бичиг бүрэн үнэн зөв цахимжсаныг тулгаж шалгасан байна.

Хяналтын улсын байцаагчийн нийт 7 дүгнэлт гарсан бөгөөд үүнээс:

- Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох - 6
- Бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах - 1

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна.




Тав. Архивын чиглэлээр:

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамаарах улсын бүртгэлийн мэдээллийн сан, архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 1276 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

2024 оны архивын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийгдэх ажлуудын хүрээнд иргэний баримтын архивын тодорхойгүй төлөвт байгаа 1995-2005 оны ХААТР-11 маягтуудыг татан авч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж бусад аймаг, нийслэлд шилжсэн, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан, нас барсан эсэхийг шалгаж хүлээлгэж өглөө.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/1437, А/110 дугаар тушаалын хавсралт, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 11/9747 дугаартай чиглэл, зөвлөмж, УБН архивын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10/601 дугаар чиглэл зэргийг үндэслэн тус хэлтсийн байгууллагын ББНШАЗК-ын 2022 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн архивт хадгалагдаж байсан хадгалах хугацаа нь дууссан ИУБ-21 маягт, ИУБ-22 маягт, лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын хадгалах хугацаа нь дууссан баримтуудын судалгаа гаргаж ББНШК-ын хурлаар хэлэлцүүлэн устгах саналыг УБЕГ хүргүүлээд байна.



Зургаа. Дотоод хяналт шалгалт болон бусад хийж хэрэгжүүлсэн ажлын хүрээнд:

Тус хэлтсийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/12 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдыг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хяналт шалгалтуудыг хийж гүйцэтгэлээ.

Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2024 оны эхний хагас жилд бүртгэсэн бүртгэлүүдийг үнэн зөв, хууль тогтоомжид нийцсэн эсэхийг түүвэрчилсэн байдлаар шалгалаа.

Улсын бүртгэгч нарт “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын 3.6-д заасны дагуу компьютерийн үйлдлийн системийн нууц үгийг сард нэг удаа, цахим мэдээллийн санд нэвтрэх нууц үгийг улиралд нэг удаа сольж байх, цахим мэдээллийн санд нэвтрэх эрхээ бусдад дамжуулахгүй байхыг анхааруулж, тус журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, албан хаагчдын ажлын цаг ашиглалтанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

Долоо. Захиргааны хэргийн шүүхэд маргаантай байгаа асуудлаар:

Иргэн Л.Мялдорж болон нэр бүхий 17 иргэний нэхэмжлэлтэй Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 7480 дугаартай дүгнэлт нь “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн хувьцаа эзэмшигч бидний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тул хүчингүй болгож, Хөвсгөл гурил тэжээл ХХК-д миний болон миний төлөөлж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьцааг бүртгэхийг даалгасан шийдвэрийг гаргуулах тухай нэхэмжлэлд:

Мөн Л.Ганбатын “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ний гүйцэтгэх удирдлагын мэдээлэлд 2009 онд орсон өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсан Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Улсын бүртгэлийн ерөнхий газрын эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож, Хөвсгөл гурил тэжээл ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын 2009 оны өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхийг Хөвсгөл аймгийнх Улсын бүртгэлийн хэлтэст даалгах тухай” нэхэмжлэлд, нэхэмжлэлийн шаардлага ихэсгэж “Хөвсгөл гурил тэжээл” ХХК-ийн хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг бүртгэсэн улсын бүртгэгч Н.Азжаргалын 2023 оны 03 дугаар сарын 25-ны бүртгэлийг хүчингүй болгох” нэхэмжлэлтэй, захиргааны хэргийг хянан шийдвэрлэх анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр нэхэмжлэлийн хувийг гардан авах, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.2 дахь хэсэгт заасан хариуцагчийн эрхийг эдэлж, үүрэг хүлээх, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2.1, 28.2.6, 28.2.8 дахь заалтад заасан төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэн шүүх хуралд тус тус оролцож байна.

Мөн Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын иргэн О.Цэрмаагийн “Охин Бат-Амгалангийн Тэмүүнзаяагийн овог эцгийн нэрийг өөрчилж Буддовчингийн Тэмүүнзаяа болгон өөрчлөхийг Улсын бүртгэлийн хэлтэс даалгасан шийдвэр гаргуулах тухай” нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хариуцагчаар , “Шидэт гал” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Ү-1723009130 дугаартай Хөвсгөл аймгийн Мөрөн сум 8-р баг, 49 тоот байрны 1, 3 ,4, 5, 8, 11, 12, 13, 16, 21, 24, 25, 26, 27, 30, 31, 32, 34, 35 тоот орон сууцанд болон 30 авто зогсоолд тус тус урьдчилан тэмдэглэгээ хийсэн бүртгэлийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлд тус тус одоогийн байдлаар хариуцагчаар оролцоод байна.

Түүнчлэн хяналт шалгалт, зөрчлийн бүртгэлийн нэгдсэн санд шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны материалаыг тухай бүр цахимжуулан ажиллаж байна.

Найм. Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд:

-Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих ажлыг сайжруулах ажлын хүрээнд эхний хагас жилд нийт 50 өргөдөл, хүсэлт иргэн, хуулийн этгээд, улсын бүртгэгч нараас ирсэнийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргаж холбогдох тасаг болон иргэнд хүргүүлэн шийдвэрлэлээ.

- Эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах зорилгоор хяналт шалгалтыг эрчимжүүлэх, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлагын арга хэмжээ авах ажлын хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шинээр үүсгэн байгуулагдсан 613 аж ахуй нэгжүүд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байна.

-Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 1/655 дугаар үүрэг чиглэлийн дагуу мөн Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хяналтын улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтнууд 3940 иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хөтлөх үйл ажиллагаанд холбогдуулан хяналтын улсын байцаагч нар өөрийн харъяалах нэгжид бүртгэгдсэн бүртгэлийг шалгаж ажиллалаа. Энэхүү шалгалтыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүрэг, чиглэлд заасан ажлыг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлж ажиллалаа.

-Хууль, журам, албан тушаалын тодорхойлолтод заасан улсын бүртгэлийн хууль тогтоомжийг биелүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бүртгэлийн зөрчлийг гаргахгүй байх талаах нийт бүртгэгч нарт болон албан хаагчдад үүрэг даалгавар өглөө.

-Архивын эх нотлох баримт цахимжуулах, лавлагаа олгох үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хүрээнд нийт 1146 архивын эх нотлох баримтыг Иргэний улсын бүртгэлийг цахимжуулсан материалыг харах, ашиглах, засварлах программ хангамжаас бүрэн цахимжсан эсэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг EPRS-2 программаас мета дата буюу бүртгэлийн төрлөөр цахимжсан эсэх, Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийг ERS программаас үйлчилгээний нэршил зөв орсон эсэхийг тус тус нотлох баримттай тулган шалгасан байна.

6. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтэс нь 2024 онд батлагдсан 1 609 555 300 төгрөгийн төсвөөс 11 сарын байдлаар 1 470 896 100 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 243 395 223 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын задаргаа:

- Иргэний гэр бүлийн 8н төрлийн үйлчилгээ 6 285 000
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл 3 623 000
- Иргэний цахим үнэмлэх 75 550 000
- Хил зорчих үнэмлэх 2 046 000
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 132 316 223
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл 23 575 000

Мөн Аймаг, орон нутгийн орлогод улсын тэмдэгтийн хураамж орлого:

- Шилжилт хөдөлгөөний бүртгэлээс 2 132 000.00 төгрөг,
- Цахим үнэмлэхний үйлчилгээнээс 2 2242 000.00 төгрөг,
- Гадаад паспортын үйлчилгээнээс 34 605 000.00 төгрөг,
- Үл хөдлөх хөрөнгийн анхны бүртгэлийн үйлчилгээнээс 10 597 166.00 төгрөг,
- Үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлогоос 645 088 583.00 төгрөг,
- Хуулийн этгээдийн бүртгэлээс 26 972 000.00 төгрөг,
- Хүү торгуулийн орлогоос 4 240 000.00 төгрөг нийт 745 876 749.00 төгрөгийг оруулсан байна.

Сар бүрийн орлогын мэдээг тасгуудаас авч нэгтгэн УБЕГазарт хүргүүлж байгаа бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг УБЕГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу орлогын нэр төрөл, мөнгөн хөрөнгийн данс бүрээр, өглөг авлагын задаргаа бүрээр цаг хугацаанд чанартай гарган УБЕГазарт хүргүүлэн, Шилэн дансны сайт, Хөвсгөл УБХэлтсийн мэдээллийн сайт, байгууллагын “Санхүүгийн ил тод байдлын” самбарт нээлттэйгээр байрлуулан ажиллаж байна. Мөн Шилэн дансны сайтад Гадаад паспортын шинэчлэгдсэн үйлчилгээний үнэ тариф, 2023 оны аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн мэдээ тайланг цаг хугацаанд нь шивэн оруулж 11 дүгээр сарын байдлаар 171 мэдээлэл оруулахаас 139 мэдээллийг хугацаанд нь оруулж 2024 оны 3 дугаар улирлын шилэн дансны тайланг илгээгээд байна. 2024 оны Төрийн өмч эзэмшүүлэх гэрээг 81% /хангалттай/ дүгнүүлсэн.

Бүртгэгч нарын 2024 оны 1-10 сарын үнэт цаасны кодтой тайланг хугацаа хоцроогүй нэгтгэн УБЕГазрын санхүүд хүргүүлээд байна.

Монгол Улсын Их хурлын болон Аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулиар 246.962.768 төгрөгний санхүүжилтыг зориулалтын дагуу зарцуулсан.

Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу 2023 оны санхүүтэй холбоотой баримт бичгээ байгууллагын архивт хүлээлгэн өгч Байгууллагын архивын эмх цэгц, баяжилтад гар бие оролцон цэгцэллээ.

Сангийн яамнаас хэрэгжүүлж буй онлайн программ болох цалин хөлсний PAYROLL программ, төрийн сангийн төлбөр тооцооны Finance программуудаар нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээгээ хийж гүйцэтгэж байна. Мөн ХЗДХЯамнаас хэрэгжүүлж буй төсвийн гүйцэтгэлийн OPENGOV программд сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон 2025 оны төсвийн төслийг шивж оруулаад байна.

Ажиллагсдын цалингийн тооцооллыг сард 2 удаа бодож, 2 программаар бодон тулган шалгаад, Нийгмийн даатгалын тайланг цалингийн программаас Нийгмийн даатгалын Portal систем руу excel файл руу хөрвүүлэн илгээж байгаа.

Хүний нөөцийн нэгдсэн системээс албан хаагчийн цалинтай холбоотой мэдээллийг сар бүр шинэчлэн татаж тулган баталгаажуулан цалинг тооцоолон татварын суутганы тайланг PAYROLL программаас татан оруулж тайлангаа цаг хугацаанд нь илгээн ажиллаж байна.

2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 3 хоног ХЗДХЯамнаас хэрэгжүүлж буй Эрин системийн e-account санхүүгийн программын сургалтад хамрагдан 2023 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, материалын үлдэгдлийг зааврын дагуу оруулж 2024 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайлан гаргаж хүргүүлсэн.

Тайланг хугацаанд УБЕГазраас татан авах үнэт цаас, бараа материалыг машин техник хүн хүчний боломжоороо тасралтгүй ханган байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тасалдуулалгүй ажиллаж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг код бүрээр тулган баталгаажуулж заасан хугацаанд нь УБЕГазрын санхүүд нэгтгэн хүргүүлж байна.

2024 онд тус хэлтэс нь 47 орон тоо батлагдсанаас 45 орон тоотойгоор бүртгэлийн үйл ажиллагааг тасалдалгүй хэвийн явуулж 2 сумын бүртгэгчийн орны томилгоо хийгдээгүй бөгөөд Мөрөн сумын улсын бүртгэгч С.Дэлгэрмөрөн Бүрэнтогтох сумын бүртгэлийг, улсын бүртгэгч Б.Болормаа Алаг-Эрдэнэ сумын бүртгэлийг, Түнэл сумын улсын бүртгэгч Н.Дандар Ханх бүртгэлийг 14 хоног тутам томилолтын зардал гаргалгүйгээр хийж гүйцэтгэж байна.

7. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Хэлтсийн нярав, бичиг хэргийн ажилтан нь байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Тус хэлтэс нь тайлант хугацаанд 1359 албан бичгийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан бөгөөд 1355 албан бичгийг хүлээн авсан үүнээс 945 нь хариутай албан бичиг байсан ба холбогдох хариуг цаг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн. Нийт бичиг хэргийн эргэлтийн тоо 1359. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 23 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 4, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 19-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 128 өргөдөл, гомдол ирсэн ба өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, 100% шийдвэрлэж ажилласан байна. Бичиг хэргийн цахим программ болох ERP програмаар 301 албан бичиг хүлээн авч, 237 хариутай албан бичгийн хүргүүлэн ажилласан. Мөн EDOC програмаар нийт 576 албан бичиг хүлээн авч, 326 албан бичгийг хэлтсийн даргын тоон гарын үсгээр баталгаажуулан байгууллагуудад хүргүүлсэн. Мөн Khuvsqul@burtgel.gov.mn, uburtgel@khs.gov.mn, 21aimag@burtgel.gov.mn төрийн цахим хаягаар бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийг хүлээн авч, холбогдох албан хаагчид шилжүүлэн хариутай албан бичгийн хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд тоон гарын үсэг ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх албан бичгийг тоон гарын үсгээр баталгаажуулан EDOC програмаар хүргүүлж, бичиг хэргийн зардлыг хэмнэн ажиллаж хэвшсэн байна. Хэлтсийн байгууллагын архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж, хадгаламжийн нэгжийн бүртгэлийг шинэчлэн бүртгэл хадгаламжийн нэгжүүдийг оноор, оны дотор хадгаламжийн нэгжүүдийг баримтын ач холбогдлоор нь дараалуулан байрлуулж, хадгаламжийн хугацаа дууссан баримт бичгийг устган ажилласан болно.

Хэлтсийн албан бичгийн 2024 оны жилийн эцсийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2022 он	988	441	1439	1344	12	22	34	42
2023 он	879	671	1550	1341	2	21	23	122
2024 он	945	400	1355	1359	4	19	23	128

Албан бичгийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 114 өргөдөл
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 8 өргөдөл
- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой – 6 өргөдөл
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 0 өргөдөл
- Албан хаагчтай холбоотой гомдол – 0
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 0
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 0 нийт 128 өргөдөл, авсан байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийн шийдвэрлэлтээр авч үзвэл:

- Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 58
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт албан бичгээр хүргүүлсэн 11
- Албан бичгээр хариу хүргүүлсэн 31
- Утсаар холбогдон иргэнд холбогдох мэдээлэл заавар зөвлөмж өгсөн 10
- Бүртгэлийн дэвтрээс засалт хийгдсэн 15
- Нэгдсэн дүгнэлтээр залруулсан 3

Тус тус өргөдлийг хяналтын карт хөтлөн бүртгэлийн дэвтр дээр бүртгэн даргын цохолтын дагуу албан хаагчдад өгч шийдвэрлүүлэн ажиллаж байна.

8. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Хэлтэст зохион байгуулах 2024 оны сургалтын төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 14 арга хэмжээтэй боловсруулж хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 23, Улсын бүртгэлийн ерөнхий газраас болон аймгийн ЗДТГ, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 63 удаагийн сургалтад хэлтсийн бүх албан хаагчид болон хэлтсийн дарга, холбогдох албан хаагчид бүрэн хамрагдсан байна. Мөн аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар, Хилийн цэргийн 0257 дугаар анги, Нийгмийн даатгалын газар, Прокурорын газар, Монгол банк, Төрийн банк, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Онцгой байдлын газар, Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Титэм ЕБС, Авьяас ЕБС зэрэг байгууллагуудтай хамтран сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар зохион байгуулсан.

1.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй сургалт:

-2024.03.07-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” “Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төсөл танилцуулав. Тус онлайн сургалтанд сумдын болон хэлтсийн 32 албан хаагч хамрагдлаа.

-2024.03.14-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Дижитал шилжилт, виртуал орчинд ажиллах” сумдын болон хэлтсийн 38 албан хаагч хамрагдлаа.

-2024.03.21-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” “Төрийн албан хаагчдад санхүүгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, хуримтлалын ач холбогдол”-ын талаар сумдын болон хэлтсийн 40 албан хаагч хамрагдлаа.

-2024.03.28-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2” онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 28 албан хаагч хамрагдлаа.

-2024.04.04-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Төрийн албаны үнэт зүйл /эрхэмж/, үе хоорондын ялгаатай байдал онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 22 албан хаагч хамрагдлаа.

-2024.04.11-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Монгол төрийн зүтгэлтний хэв шинж” онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 43 албан хаагч хамрагдлаа.

-2024.04.18-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны явц онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 37 албан хаагч хамрагдлаа.

-2024.04:25-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийн хүрээнд “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг хэрэгжүүлэх талаар 7:4:10” онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 32 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.02-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”- Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо сэдэвээр онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 35 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.09-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “БНСУ-ын төрийн албаны сонгон шалгаруулалтын ёрөнхий тойм, онцлого” онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 28 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.16-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10”, “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” онлайн сургалтад сумдын болон хэлтсийн 36 албан хаагч хамрагдлаа.

2024.05.23-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “Төрийн албаны шинэтгэл буюу цэгцрэх хөдөлгөөн” сургалтад сумдын болон хэлтсийн 20 албан хаагч хамрагдлаа.

2024.05.30-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагын талаар мэдээлэл түгээх сургалтад сумдын болон хэлтсийн 15 албан хаагч хамрагдлаа.

2024.06.06-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” Төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоонд гарч буй нийтлэг зөрчил, зөвлөмж өгөх сургалтад сумдын болон хэлтсийн 15 албан хаагч хамрагдлаа.

2024.09.12-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “Төрийн албан хаагчийн тасралтгүй хөгжих, гадаад улсад суралцаж, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэхэд зориулсан тэтэглэгт хөтөлбөрийн талаар мэдээлэл зөвлөгөө сургалтад сумдын болон хэлтсийн 22 албан хаагч хамрагдлаа.

2024.09.26-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “КИЙКА-гийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газрын сургалт хариуцсан ажилтан Д.Түвшинсайхан оролцож, “Төрийн албан хаагчийн суралцах идэвхийг дэмжих нь: КОЙКА-гийн тэтэглэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөмж” сэдэвт сургалтад сумдын болон хэлтсийн 22 албан хаагч хамрагдлаа.

2024.10.03-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “Нийгмийн даатгалын ерөнхий гакрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц. Ганцэцэг тус сургалтад оролцож “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр сургалтад сумдын болон хэлтсийн 26 албан хаагч хамрагдлаа.

2024.10.10-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, ”Нийгмийн даатгалын эрх зүйн орчны шинэтгэл, хуулийн хэрэглээний талаар мэдээлэл, зөвлөгөө сургалтад сумдын болон хэлтсийн 28 албан хаагч хамрагдлаа.

2024.10.10-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”Төрийн албан хаагчийн сэтгэл ханамж,түүнд нөлөөлж буй хүчин зүйл,судалгааны талаар мэдээлэл өгөх,төрийн албан хаагчийн оролцоог нэмэгдүүлэх сургалтанд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

2024.10.17-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын дарга С.Лхагвадорж оролцож, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт /нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, ажил олгогч, даатгуулагчийн эрх, үүрэг, даатгуулагчийн төрлийн код, хөөн хэлэлцэх хугацааны талаар/ сэдвээр сургалтад сумдын болон хэлтсийн 25 албан хаагч хамрагдлаа.

2024.11.05-ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, Жендэрийн үндэсний хорооноос эрэгтэй эмэгтэй хүний насжилтын зөрүү сэдэвт цахим сургалтыг Эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Батхишиг хөвсгөл аймгийн хэмжээнд сургалтыг зохион байгуулж хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

2024.11.14-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, “Төрийн албан хаагч ёс зүйн манлайллыг дэмжих,ёс зүйтэй төрийн алба сургалтанд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

2024.11.14-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10”, Төрийн албан хаагчийн ёс зүй (гомдол мэдээлэл, зөрчлийг шийдвэрлэх) сэдвээр цахим сургалтанд хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.

2. Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан сургалт:

-2024.01.09-ний Аймгийн Засаг даргын тамгын газар, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ, түүний хор хөнөөл, урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт сургалтад хэлтсийн 18 албан хаагч хамрагдлаа.

-2024.01.23-ны өдөр Хилийн цэргийн 0257 дугаар ангийн ахлагчийн зөвлөлөөс Хөвсгөл аймаг дахь төрийн байгууллагуудад алба үйл ажиллагаагаа сурталчлах аяныг эхлүүлж, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олонд Хил хамгаалах байгууллагын түүхэн замнал, ахлагчийн албаны талаар мэдээлэл хүргэж “Эх орны хилээс” урлагийн тоглолтыг зохион байгууллаа.

-2024.02.19-ний өдөр Тус хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Хилийн цэргийн 0257 дугаар ангийн Дэд хурандаа Э.Бат-Ирээдүй, Хошууч А.Оргил нар "Монгол Улсын Хилийн боомтуудын танилцуулга" сэдвээр сургалт зохион байгууллаа. Хэлтсийн албан хаагчид 100% сургалтад хамрагдлаа.

-2024.02.29-ний өдөр Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг танилцуулах, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргахгүй байх үүднээс хэлтсийн болон сумдын улсын бүртгэгч нарт сургалт зохион байгууллаа.

-2024.03.26-ны өдөр Цагдаагийн газар болон Монгол банкнаас зохион байгуулсан “Санхүүгийн луйвар залилан, гэмт хэрэг”-ээс урьдчилан сэргийлэх сургалтад хэлтсийн 16 бүх албан хаагч хамрагдлаа.

-2024.03.29-ний өдөр “Төрийн банк”-наас санхүүгийн боловсрол олгох сургалтад 20 албан хаагчид хамрагдлаа.

-2024.03.29-ний өдөр Иргэний баримтын цахимжилтын талаар онлайн сургалтанд сумдын улсын бүртгэгч болон хэлтсийн иргэний улсын бүртгэгч, ахлах улсын бүртгэгч хамарсан сургалт зохион байгуулагдлаа.

-2024.04.03-ны өдөр Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газраас “Хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл болон шийтгэлийг устгах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулагдлаа.

-2024.04.04-ний өдөр Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газраас Хүүхдийг хүмүүжүүлэхэд үүрэг хүлээгч талуудын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтанд хамрагдаж, хэлтсийн “Эцэг эхийн зөвлөл”-ийн П.Даваадулам, Б.Цэнд-Аюуш нар сургагч багш гэрчилгээгээ гардан авлаа.

-2024.04.04-ний өдөр Төрийн албан хаагчийн үндэсний бичгийг тодорхойлох судалгаанд сумдын болон хэлтсийн бүх албан хаагч хамрагдлаа.

-2024.04.09-ний өдөр УБЕГ-ын ЭХЭУБГазраас Банк болон ББСБ, банкуудын холбоотой хамтран зохион байгуулсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн өөрчлөлт хэлэлцүүлэг”-т Улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол хамрагдлаа.

-2024.04.17-ны өдөр “Улсын бүртгэлийн ерөнхий газар”-т зохион байгуулсан. “Эрин Е-Аккаунт программ”-ийн нэвтрүүлэлтийн талаар Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан сургалтанд Ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр хамрагдлаа.

-2024.04.22-ны өдөр “Цахимд хэвшье” сургалтад Хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа нар хамрагдлаа.

-2024.04.25-ны өдөр Хөвсгөл аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Д.Батсүх, прокурорын туслах н.Билгүүндаш нар "Прокурорын газрын үйл ажиллагаа" болон зөрчил шалган шийдвэрлэх сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад хэлтсийн 18 албан хаагч хамрагдлаа.

-2024.04.26-ны өдөр ХЭУБГазараас тасгийн дарга нарт зориулан зохион байгуулсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхөд анхаарах асуудал" сэдэвт онлайн сургалтанд Улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол хамрагдлаа.

-2024.04.29-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад 6 албан хаагч хамрагдлаа.

-2024.04.29-ний өдөр Согтууруулах ундааны хэрэглээг буурууланх бодлого, олон улсын хандлага сургалтад 9 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.01,06-ны өдрүүдэд ХЭУБГазраас зохион байгуулсан "Хоршооны улсын бүртгэл хөтлөх талаар мэдээлэл өгөх" сургалтад Улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол, Улсын бүртгэгч П.Даваадулам, Б.Цэнд-Аюуш нар хамрагдлаа.

-2024.05.03-ны өдөр Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Чимэдцогзол, хуулийн этгээдийн улсын бүртгэгч П.Даваадулам нар сумын улсын бүртгэгч нарт шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдуулан сургалт зохион байгуулж, чиглэл өгч сургалт зохион байгууллаа.

-2024.05.03-ны өдөр "ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ-2" аяны хүрээнд Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон ажлын байрны дасгалд нэгдлээ.

-2024.05.06-ны өдөр Сургагч багш Г.Дашжаргалын зохион байгуулсан. Энэ жилдээ Эрүүл жиндээ-2 аяны хүрээнд хэлтсийн албан хаагчид эрүүл зөв амьдралын хэвшил олгох сургалтад хамрагдлаа.

-2024.05.07-ны өдөр Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сургалтад хэлтсийн 18 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.08-ны өдөр "Цусны донор болох" талаар сургалтад 19 албан хаагч хамрагдлаа.

-2024.05.21-ний өдөр "Хилийн цэрэг"-ээс Ахлагч Б.Нямсайхан, Сэтгэл зүйч Р.Ганчимэг нарын зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны ур чадвар, сэтгэл зүйн талаар сургалтад 16 албан хаагч хамрагдлаа.

-2024.06.14-ны өдөр тус хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлууд, сонгогчийн бүртгэлийн программ хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, сумдын улсын бүртгэгч болон хэлтсийн бүх албан хаагч тус сургалтад хамрагдлаа.

-2024.06.19-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар Хөвсгөл аймгийн 129 хэсгийн хороонд ажиллах 132 итгэмжлэгдсэн ажилтны “Эрх зүй, мэдээлэл технологийн” сургалт амжилттай зохион байгууллаа.

-2024.08.15-ны өдөр УБЕГ-ын даргын А/131 тушаалын дагуу Бүсчилсэн сургалт зохион байгуулах хүрээнд Дорнод аймагт зохион байгуулагдсан. УБЕГ-аас Архивын баримтын хадгалалт хамгаалалт, нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа анхаарах асуудалын талаар Улсын бүртгэлийн нэгдсэн ахлах архивч Г.Хүчитбаатар мэдээлэл өгч сургалтанд бүх албан хаагчид хамрагдсан байна.

-2024.08.14, 15-ны өдрүүдэд УБЕГ-ын даргын А/131 тушаалын дагуу Бүсчилсэн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн практик хэрэглээ, анхаарах асуудал”, “Эд хөрөнгийн эрхийн цахим системд хөтлөхөд анхаарах асуудал”, “Бүртгэлийн системүүд, тэдгээрийн нэмэлт өөрчлөлт ба цахим үйлчилгээ”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай ойлголт, хууль тогтоомж”-ын хүрээнд “Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх ажлын хүрээнд улсын бүртгэлийн чадвахыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, төв, орон нутгийн албан хаагчид үйл ажиллагааны туршилга солилцох”, сургалт Дорнод аймгийн буйр нууранд зохион байгуулсан тус сургалтад хамрагдсан.

-2024.08.22, 23, 24-ний өдөр Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөл болон Иргэний нисэхийн Ерөнхий газраас Хөвсгөл аймаг дахь “Мөрөн” нисэх буудалд “Барилга байгууламжийг тэсрэх хэрэгслээр занилхийлэх” сэдэвт хамтарсан танхимын сургалтад Хэлтсийн дарга Б.Мөнгөнзул, Иргэний улсын бүртгэлийн архивч Б.Маналжав, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ө.Батнасан нар хамрагдлаа.

-2024.08.26,27-ны өдөр Худалдаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал ба компани байгуулах болон өөрчлөлтийн бүртгэлийн талаар сургалт зохион байгуулагдлаа. Тус сургалтад хуулийн этгээдийн улсын бүртгэгч П.Даваадулам хамрагдлаа.

2024.09.01-14-ний өдрийн хооронд Бүгд найрамдах Солонгос улсад “Монгол Улсын Үндэсний бүртгэлийн системийн Дижитал чадамжийг бэхжүүлэх хөтөлбөр” сургалтад Иргэний улсын бүртгэгч Б.Болормаа хамрагдсан.

-2024.09.29-ний өдөр Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуулиар Хөвсгөл аймгийн 129 хэсгийн хороонд ажиллах 132 итгэмжлэгдсэн ажилтны “Эрх зүй, мэдээлэл технологийн сургалт” амжилттай зохион байгуулагдлаа. Тус сургалтад 132 итгэмжлэгдсэн ажилтан хамрагдлаа.

-2024.10.18-ны өдөр Аудитын шийдвэргийг хэрэгжүүлэхэд харилцагч талуудын оролцоог нэмэгдүүлэх тус сургалтад хэлтсийн Ахлах нягтлан бодогч Б.Мөнхдэлгэр, Иргэний Улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа нар хамрагдлаа.

-2024.10.18-ны өдөр “Кибир аюулгүй байдал”-ын сургалтад Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Цэнд-Аюуш, Иргэний улсын бүртгэгч О.Ням-Оджаргал, Б.Мөнхжаргал Бичиг хэрэг эрхлэгч Б.Содномцэрэн нар хамрагдлаа.

2024.10.18-ны өдөр Shilen.gov.mn мэдээллийн сургалтад Мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа хамрагдсан.

-2024.10.25-ны өдөр тус хэлтсийн 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3" хүрээнд Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, зорилгоор төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу эхний ээлжинд хэлтсийн албан хаагчдаас Титэм ЕБС-н багш Т.Нарандаваатай хамтран түвшин тогтоох шалгалт авч үе шатлалтайгаар сургалтыг зохион байгуулж хэлтсийн бүх албан хаагчид хамрагдаж амжилттай зохион байгуулагдаж байна.

-2024.10.28-ны өдөр Хэлтсийн "Хүний эрхийг хангах" болон "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах" 2024 оны төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдад дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний төвийн мэргэжилтэн Х.Хишигбаяр зохион байгууллаа. Тус сургалтад сумдын болон хэлтсийн 25 албан хаагчид танхим болон онлайнаар бүрэн хамрагдан ажиллалаа.

-Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын "Авьяас" сургуулийн ахлах ангийн 38 хүүхдэд Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэргэжлийн талаар танилцах өдөрлөгийг зохион байгууллаа. Сурагчид хэлтсийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай танилцлаа.

-2024.10.29-нд Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Г.Болортуяа хэлтсийн нийт албан хаагчдад "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх", "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах", "3 үгт хаяг байршил" сэдвээр сургалт зохион байгууллаа.

2024.10.30нд Хөвсгөл аймгийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих ахлах прокурор С.Батсүх, прокурорын туслах Ж.Чингэл нар "Зөрчлийн тухай хууль" болон "Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ" сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтад хэлтсийн болон сумын улсын бүртгэгч нар хамрагдлаа.

Тус аймаг нь 24 сум 1 тосгонтой бөгөөд хилийн боомт 1, хил орчмын 10 сум байдаг. Хилийн сум болон хил орчмын сумдад жилдээ 1-2 удаагийн “Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж, 9 суманд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон нь иргэдийн хувьд илүү хялбар, түргэн шуурхай болсон ч нөгөө талаас сумдад гадаад паспортыг хүргүүлэх шуудангийн зардал нэмэгдэж байна. Мөн хил зорчих үнэмлэх олголт буюу цагаан хуудас буурсан үзүүлттэй байгаа юм.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг Баянзүрх, Галт, Их-Уул, Тариалан, Хатгал, Улаан-Уул, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Рашаант, Цэцэрлэг, Эрдэнэбулган сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосон Ингэснээр 12 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл **823**, хуулийн этгээдийн улсын бүртгэл **110** хөтлөгдсөн байна. Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх болсонтой холбоотойгоор иргэдийн эд хөрөнгөө бүртгүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах таатай нөхцөл бүрдсэн ч нотариатын үүрэг гүйцэтгэгч, газрын даамал, иргэдийн хурал /газрын хаягжилтын тогтоол/, банк зэрэг байгууллагын албан хаагчдыг ажлын хариуцлагын сайжруулах, чадавхжуулах тал дээрх байгууллагын дээд шатны удирдлагатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Иргэний улсын бүртгэлийг өмнөх оны тайлант хугацаатай харьцуулахад 1.38%, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 0.6%, хуулийн этгээдийн улсын бүртгэл 31%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэл өссөн нь Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй холбоотой бөгөөд хоршооны бүртгэлийг 2023 оны тайлант хугацаатай харьцуулахад 205 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэлтсийн хэмжээнд иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 4G төхөөрөмж ашиглан алслагдсан сум, багийн иргэдэд хүртээмжтэй хүргэх боломж бүрдсэн ч бензийн шатахуун, томилолтын зардал төсөвт тусгагдаагүй байдал нь албан хаагчдын ажиллах нөхцлийг бүрэн гүйцэд хангаж чадахгүй байна.

Хэлтсийн үйлчилгээний зааланд дугаар дуудагч машиныг ашиглаж эхэлснээр үйлчилгээний соёлыг нэвтрүүлж ажиллалаа.

Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт цаг хугацаа, төлбөр мөнгө, насны ангилал, хот, хөдөө гэж ялгахгүйгээр дээд шатлалын нарийн мэргэжлийн үзлэг оношилгоонд хамруулах боломжоор хангах шаардлагатай байна.

Хэлтсийн болон аймгийн төвийн албан хаагчдын хөдөө орон нутагт ажилласан нэмэгдлийг ялгаварлалгүйгээр /орон нутгийн орлого харгалзахгүйгээр/ олгох ажлыг Засгийн газарт уламжлуулах хүсэлтэй байна.

Улсын бүртгэлийн байгууллагын нууцын баталгаа гаргадаг албан хаагчдын мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоо, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, ажил үүргээ явуулах нөхцлөөр хангах, эрүүл мэнд, сэтгэл санааны аюулгүй байдлыг зохицуулах зорилгоор эрх зүйн байдлыг хуульчилж өгөх шаардлагатай байна.

Хэлтсийн архивын зориулалттай 2 өрөө нь архивын баримт бичгийг хадгалах даацаас хэтэрсэн тул зориулалтын бус бүртгэгчийн өрөө болон 00н өрөөг тохижуулан архивын баримтыг хадгалж байна. Иймд тус хэлтсийн байранд архивын тухай хуульд заасан стандартын шаардлага хангасан өргөтгөлийн байртай болох шаардлага үүсээд байна.

Дүгнэлтэд дурдсан тулгамдсан асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө болон албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд тусгуулах саналтай байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЖИЛТАН

Э.НАРАНТУЯА

ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНГӨНЗУЛ

